Гаалийн ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын .........-ний өдрийн ...... дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

**ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

АЛСЫН ХАРАА: Итгэлтэй, ил тод, инновацыг дэмжсэн байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ.

ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах,

ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх,

ЗОРИЛТ 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх,

ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

| д/д | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих | | | | | | |
| 1 | ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах, | Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын | Хэрэгжилт, хувиар | 2020 он<br>-Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн хэрэгжилт 26.5 хувьтай.<br>-Монгол Улсын Худалдааны бодлогыг Дэлхийн худалдааны байгууллагаар 2021 онд хянуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тайланд 2013-2019 оны “Гаалийн хяналт, бүрдүүлэлт, гадаад худалдааны статистик мэдээлэл, | 2021 он<br>Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн 6 заалт<br>(1.3. Лавлах цэг;<br>2.1. Санал өгөх боломж олгох, хүчин төгөлдөр болохоос өмнө мэдээлэл өгөх;<br>5.1. Хяналт, шалгалтыг чангатгах талаар мэдэгдэл хүргүүлэх;<br>7.2. Цахим төлбөр;<br>7.9. Түргэн мууддаг бараа;<br>10.5. Ачилтын өмнөх | ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хорооны хэрэгжилтийг хангах хүрээнд ДХБ-ын Нарийн бичгийн даргын газарт 2021 онд 6 заалт, 2022 онд 8 заалттай холбоотой гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн ажлын тайланг Монгол Улсын Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороогоор уламжлуулан хүргүүлсэн. Үүний үр дүнд 2020 онд 26.5 хувьтай байсан гүйцэтгэл 2022 онд 79.9 хувьд хүрсэн. Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааны хүрээнд ДГБ-аас худалдааг хөнгөвчлөх чиглэлээр онош зүйн шинжилгээ хийсэн ба тус байгууллагын үнэлгээгээр 2 төвшин буюу 57 оноогоор үнэлэгдэн, цаашид хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг 2023 онд хэрэгжүүлэхээр, холбогдох төлөвлөгөөг гарган ажиллаж байна.<br> ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн хурлыг 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Худалдааны бодлогыг хянасан 2021 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | | оюуны өмч, тариф, татвар, барааны ангилал, гарал үүсэл, гаалийн үнэлгээ, гадаад худалдааг хөнгөвчлөх” талаарх мэдээллийг нарийвчлан гаргаж өгсөн.<br>-Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн:<br>“9. Импортын барааг гаалийн хяналтын дор тээвэрлэх;<br>7.4. Эрсдэлийн удирдлага;<br>3. Урьдчилсан шийдвэр;<br>7.6.Бараа олгох дундаж хугацааг тогтоож, хэвлэн нийтлэх;<br>7.7.Итгэмжлэгдсэн операторуудад зориулсан худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ;<br>7.8.Түргэвчилсэн бүрдүүлэлт хийлгэх ачаа;<br>8.Хилийн хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа;<br>10.6.Гаалийн зуучлагч ашиглах;<br>5.3. Шинжилгээний журам;<br>6.3. Торгууль шийтгэлийн тухай журам;<br>12. Гаалийн хамтын ажиллагаа” заалтын хэрэгжилтийг хойшлуулах, үүнтэй уялдуулан техникийн туслалцаа авах хүсэлтийг Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны хуралдаанд танилцуулахаар төлөвлөсөн. | шалгалт)-ын биелэлтийг хүргүүлсэн байна. Хэрэгжилт 56.3 хувьтай байна.<br>2021 онд Монгол Улсын Худалдааны бодлогыг Дэлхийн худалдааны байгууллагаар хянуулахтай холбоотой “Худалдааны бодлого хянуулах ажлын хэсэг”-т орж ажиллан, холбогдох мэдээллийг хүргүүлсэн байна.<br><br>2022 он<br>Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-ийн 8 заалт<br>(19. Импортын барааг гаалийн хяналтын дор тээвэрлэх;<br>10.6. Гаалийн зуучлагч ашиглах;<br>1.1. Хэвлэн нийтлэх;<br>1.2. Интернэтээр дамжуулан авах боломжтой мэдээлэл; 7.1. Урьдчилсан бүрдүүлэлт; 7.3. Бараа олгох ажиллагааг, гаалийн болон бусад татварыг, мөн төлбөр, хураамжийг эцэслэн тодорхойлох ажиллагаанаас ялган салгах;<br>10.9.1. Барааг түр хугацаагаар оруулах, барааг дотоодод болон гадаадад боловсруулах)-ын биелэлтийг хүргүүлсэн байна.<br>Хэрэгжилт 64.6 хувьтай (43.7+20.9) байна. | зохион байгуулж “ДГБ-ын Меркатор хөтөлбөрийн хүрээнд ажилласан тайлан, төлөвлөгөө; ДГБ-аас БДШ-ын чиглэлээр ажилласан тайлан, төлөвлөгөө; Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган, баталж, ДГБ, Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хороонд тус тус хүргүүлэн үйл ажиллагаагаа сайжруулахаар ажиллаж байна. ДХБ-аас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянан үзэж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд Худалдаан дахь техникийн саад тотгор, Эрүүл ахуй, амьтан ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр үйл ажиллагааг сайжруулах ажил тусгагдсан. Иймд ДБ группийн Экспортыг дэмжих төсөлтэй хамтран "ЯПОН, БНСУ-ын зах зээлд амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбоотой эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага" сургалтын хөтөлбөр боловсруулан, төслийн цахим хуудаст байршуулсан. Сургалтын хөтөлбөрийн дэлгэрэнгүй унших материал (130 хуудас)-ыг Захиргаа, дотоод ажлын систем программд оруулан гаалийн албан хаагч нарын хүртээл болгосон.<br>**Үнэлгээ: 100 хувь.** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын Худалдааны бодлогыг дүгнэсэн 2021 оны тайлангийн хэрэгжилтийг хангасан байна. | |
| 2 | ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах, | Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 2020 он<br>-Хилийн хяналтын 4 байгууллагын хяналтын дэд бүтцийг бэхжүүлэх шинэчлэлийн ажил Монгол Улсад хийгдэж эхэлсэн.<br>Хил залгаа улсын хилийн хяналтын байгууллагатай жил бүр холбоо баригч дарга нарын уулзалтыг тогтмол зохион байгуулж, ажлын үр дүнг хэлэлцэж, хяналт, шалгалтад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж ирсэн.<br>-Хөрш орнуудтай гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийх ажил тогтмолжсон.<br>-БНХАУ-ын талтай хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг 2009 оноос эхлүүлж, өдгөө хамтарсан манифестийг Монгол-Хятадын бүх хилийн боомтод цахим хэлбэрээр солилцож байна.<br>-ОХУ-ын ХГА-тай гаалийн мэдүүлэг, барааны рентген зураг солилцож эхэлсэн.<br>БНХАУ -ын Гаалийн ерөнхий газартай хорио цээрийн чиглэлээр 2 протокол байгуулсан. | 2021 он<br>-Хил залгаа улсын хилийн хяналтын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж, холбоо баригч дарга нарын уулзалтаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэн, гаалийн хяналтыг харилцан хүлээн зөвшөөрөх санал хүргүүлнэ.<br>-БНХАУ-ын Гаалийн байгууллагатай Хамтарсан хяналтын хоёрдугаар шат болох хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр хамрах хүрээг өргөжүүлэх санал солилцоно.<br>-БНХАУ болон ОХУ-тай 2020 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.<br><br>2022 он<br>-Худалдааны түнш орнуудтай гадаад худалдааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцох санал боловсруулсан байна.<br>-БНХАУ-ын Гаалийн байгууллагатай "Пүүний жинг хүлээн зөвшөөрөх, "Хилийн боомтын хяналтын судалгаа хийх" ажлыг сонгон авсан хилийн боомтод туршилтаар эхлүүлнэ. | "Дэлхийн нийтийн КОВИД-19 цар тахал гарсны улмаас биет хэлбэрээр төлөвлөсөн ажлууд цахим хэлбэрт шилжсэн. Хэдий тийм боловч хөрш орнуудтай хил нээх, хаах, барааны урсгалыг түргэсгэх, хязгаарлагдмал байдлаар нэвтрэх асуудал зэргийг шийдвэрлэх хүрээнд ойролцоогоор 720 удаа мэдээлэл солилцон ажилласан (Цахим захидал, албан бичиг, шуурхай уулзалт гэх мэт). БНХАУ-тай стратеги төлөвлөгөөнд тусгасан асуудлыг шийдвэрлэх хүрээнд ""Гаалийн зөрчил, хамтарсан хяналт, шалгалт, боомт, статистик, захиргааны чиглэл""-ээр байнгын холбоотой ажиллаж, экспортын нүүрсний хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд БНХАУ-тай хийсэн гадаад худалдааны эргэлт 2021 онд 10 тэрбум ам. долларт хүрсэн. Мөн Стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжээгүй ажлыг "Монгол Улс, БНХАУ-ын гаалийн байгууллага хоорондын стратегийн хамтын ажиллагааны 2022-2026 оны төлөвлөгөө"-нд тусган 2023 оноос хилийн хорио тавигдсаны дараа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. ОХУ: Гаалийн зөрчилтэй тэмцэх чиглэлээр Сибирийн гаалийн газартай ээлжит 5 дугаар уулзалтыг зохион байгуулан ажилласан;<br>Монгол, Орос хоёр талын мэдээлэл солилцоог хөгжүүлэхтэй холбоотой шинжээчдийн уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж "Эрсдэлийн удирдлагын чиглэлээр хамтран ажиллах тухай" Хэлэлцээрийн төслийг баталж гарын үсэг зурах нөхцөлийг хүлээхээр тохиролцсон.<br>Монголын гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 10 чиглэлийн цахим сургалт зохион байгуулсан. БНХАУ, ОХУ-тай 2021 онд статистикийн зэрэгцүүлэлтийг цахим хэлбэрээр хийсэн ба, хилийн хязгаарлалт тавигдсаны дараа биет хэлбэрээр уулзаж холбогдох дүн шинжилгээг хийхээр төлөвлөж байна". 2021,2022 оны жилийн ОХУ-тай хийсэн гадаад худалдааны статистикийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | | | | | -БНХАУ-тай 2021 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.<br>-Өмнөх оны зэрэгцүүлэлтийн зөрүүний учир шалтгааныг тогтоож, зөрүүг багасгахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | мэдээллийг гаргаж ОХУ-ын гаалийн байгууллагад UTSA-SOG@ca.customs.ru цахим хаягаар болон ГЕГ-ын ГХАХ-ээр дамжуулан хүргүүлсэн. Мөн ОХУ-аас мэдээллийг хүлээн авсан. ОХУ-аас ирүүлсэн мэдээллийг өөрийн мэдээлэлтэй HS-6, 4, 2 орны түвшинд зэрэгцүүлэн зөрүүг тооцон гаргасан. Зөрүү ихтэй барааны жагсаалтыг гарган, барааг сонгон тус бүрээр зөрүүний учир шалтгааныг тогтоож, танилцуулга бэлдсэн. 2021, 2022 оны жилийн БНХАУ-тай хийсэн гадаад худалдааны статистикийн мэдээллийг гаргаж БНХАУ-ын гаалийн байгууллагад statistics@customs.gov.cn цахим хаягаар тухай бүр хүргүүлсэн ба БНХАУ-аас мэдээлэл хүлээн авсан. БНХАУ-ын гаалийн байгууллагаас хамтарсан зэрэгцүүлэлтийг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлуулах хүсэлт ирүүлсний дагуу зэрэгцүүлэлтийн ажил хойшлогдсон хэдий ч ирүүлсэн мэдээллийг өөрийн мэдээлэлтэй HS-6, 4, 2 орны түвшинд зэрэгцүүлэн, зөрүү ихтэй барааны жагсаалтыг гарган, бараа тус бүрээр зөрүүний учир шалтгааныг тогтоож танилцуулга бэлдсэн. Цар тахлын нөхцөл байдлын улмаас хөрш 2 улстай зэрэгцүүлэлтийг биечлэн хийгээгүй боловч солилцсон мэдээллийн түвшинд зэрэгцүүлэлтийг хийсэн.<br>**Үнэлгээ: 90 хувь** |
| 3 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол Улсын Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албан | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>-Гаалийн тухай хууль 2008 онд батлагдсанаас хойш нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.<br>-Монгол Улс, Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт нэгдэн орсон боловч тус хэлэлцээрийн зарчмын заалтуудыг үндэсний хууль тогтоомжид уялдуулж тусгаагүй тул Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын | 2021 он<br>-Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр, Ази Номхон далайн худалдааны хэлэлцээр болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулна.<br>-Гаалийн тухай хуулийн | Нэг. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах ажлыг зохион байгуулна.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/130 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан Үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан.<br>Хуулийн төсөл 5 хэсэг, 345 зүйл, Ерөнхий зүйл, Мэдээлэл, зөвлөгөө, лавлагаа, гомдол, Гаалийн хяналт, бүрдүүлэлт, Гаалийн бүрдүүлэлтийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тухай хууль, 2019 онд батлагдсан Татварын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн "Гаалийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах | | төслийг боловсруулах шаардлага тулгарсан учир 2017 онд төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн.<br>-2021 оны байдлаар Монгол Улсын үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт үндэсний хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан төслийг дахин шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага гараад байна. Мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 2008 онд батлагдсанаас хойш нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт тус тус орсон.<br>-2021 оны байдлаар Монгол Улсын үндсэн хууль, Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт үндэсний хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт орсон, мөн Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр, Ази Номхон далайн худалдааны хэлэлцээр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гараад байна. | шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг олон нийтэд цахимаар болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилсан, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br>-Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу өөрийн цахим сайтад байршуулж, гаалийн харилцаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгжээс санал авсан байна.<br>-Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн саналыг хүлээн авч, Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулах талаар судалж, шаардлагатай хэсгийг төсөлд тусгасан байна.<br>-Улсын Их Хурлаар батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br><br>2022 он<br>Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Гаалийн тариф, | горим, Гаалийн албаны тогтолцоо зэрэг таван хэсгээс бүрдэнэ.<br>Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн шинэчилсэн найруулгын төслийг одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/ хуультай 181 хуудас хууль зүйн харьцуулсан судалгааг хийсэн ба нэмэгдсэн зүйл, хэсэг, заалт 1588 зүйл заалт, хасагдсан зүйл, хэсэг, заалт 588 зүйл заалт, өөрчлөн найруулсан зүйл, хэсэг, заалт 93 зүйл заалт, өөрчлөлт орсон зүйл, хэсэг, заалт 335 зүйл заалт, хэвээр үлдсэн 584 зүйл, хэсэг, заалт байна.<br>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд нийт 168 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинээр нэмсэн Бүлэг-1, Зүйл-4, заалт 85, нэмэлт өөрчлөлт оруулсан заалт-45, хүчингүй болгох заалт-24 тус тус байна. Энэ нь одоо мөрдөж байгаа хуулийн нийт заалтын 48 хувьд өөрчлөлт орсон байна.<br><br>Хоёр. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг олон нийтэд цахимаар болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилсан, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br>Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг коронавирус /COVID-19/ -ын цар тахлын халдварын нөхцөл байдлын улмаас Гаалийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулан, харьяа гаалийн газар, хороодоос албан бичгээр санал авч, цахим хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Саналыг нэгтгэн үзэхэд нийт 75 санал ирүүлсэн.<br><br>Гурав, Дөрөв. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу өөрийн цахим сайтад байршуулж Гаалийн харилцаанд оролцогч ирэн, аж ахуйн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаалийн татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэн, батлуулах арга хэмжээг авсан байна. | нэгжээс санал авч, төсөлд тусгасан байна.<br>Гаалийн ерөнхий газрын цахим хуудсанд 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдөр “Гаалийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга” цонх үүсгэж, дараах линкэд https://customs.gov.mn/component/content/article?id=830 Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эх бичвэр, байршуулж, санал авч төсөлд тусгасан.<br>Ирүүлсэн саналыг үзэхэд “Гаалийн хяналт, бүрдүүлэлт; Гаалийн байгууллага” гэсэн хоёр чиглэлээр нийт 75 санал ирсэн ба тэдгээрийг нэгтгэн Ажлын хэсгээр нэг бүрчлэн хэлэлцүүлэн 14 саналыг хуулийн төсөлд тусгаж, 24 саналыг одоогийн хууль тогтоомжоор зохицуулж байгаа гэж үзсэн, 37 санал хуулийн төслийн агуулга, зарчим, зохицуулалттай давхардсан тул төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн.<br><br>Тав. Улсын Их Хурлаас батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн байна.<br>Гаалийн ерөнхий газрын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 02/2215 албан бичгээр Үзэл баримтлалын төсөл, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, Хуулийн төслийн зардлын тооцоо, Хууль тогтоомжийн үр нөлөөний судалгаа, Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эх бичвэр, Гаалийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг Сангийн яаманд хүргүүлсэн болно.<br>**Үнэлгээ: 70 хувь** |
| 4 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, | Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах | Хадгаламжийн нэгжийн цахимжилт | 2020 он<br>-Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 30-40 хувь нь цахимжсан. | 2021 он<br>-Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 90 хувь нь цахимжсан байна. | 1.Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.1.6-д заасны дагуу байнга хадгалах хадгаламжийн нэгжээс цахим хэлбэрт нийт 500 хадгаламжийн нэгж буюу 105200 хуудас баримтыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чадавхыг бэхжүүлэх | | , хувиар, Хэрэгжилт, хувиар | -Түр болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийг цахимжуулаагүй.<br>-Бичиг хэргийн программд хөгжүүлэлт хийх шаардлагатай. | -Бичиг хэргийн программыг боловсронгуй болгох хөгжүүлэлт хийж, хэрэглээнд 100 хувь нэвтрүүлсэн байна.<br><br>2022 он<br>-Байнга хадгалах хадгаламжийн нэгжийг 100 хувь цахимжуулсан байна.<br>-Түр болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийг цахимжуулах ажлыг эхлүүлж, 10 хувьтай хийгдсэн байна.<br>-Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод хоорондын албан бичиг хүлээн авах, хүргүүлэх ажлыг цахимжуулах бодлогын даалгаврыг боловсруулсан, хэрэгжилт нь 20 хувьтай байна. | цахимжуулсан.<br>2021 онд байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 50 хувийг, 2022 онд 95 хувийг цахимжуулж, биелэлт 97,8 хувьтай хангагдсан байна. Цахимжуулалтын хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар буюу 263 баримтаар өссөн үзүүлэлттэй байна.<br>2.Гаалийн ерөнхий газрын бичиг хэргийн программыг боловсронгуй болгох хөгжүүлэлт хийж, хэрэглээнд 100 хувь нэвтрүүлсэн, Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод хоорондын албан бичиг хүлээн авах, хүргүүлэх ажлыг цахимжуулах бодлогын даалгаврыг боловсруулсан, хэрэгжилт нь 20 хувьтай байна.<br>-Албан хэрэг хөтлөлтийн стандарт, хэрэгцээ шаардлагад нийцүүлж, Гаалийн ерөнхий газрын бичиг хэргийн программыг боловсронгуй болгох программын бодлогын даалгаврыг боловсруулсан.<br>“Архив, албан хэрэг хөтлөлтийн систем” болон “Албан хэрэг хөтлөлтийн гар утасны программ” нийлүүлэгч “Ньюсоник” ХХК-ийн захирал Д.Анхбаяртай 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр уулзалт хийж, бүтээгдэхүүн үйлчилгээг нь судлах зорилгоор туршилтаар ашиглахаар хэлэлцсэн.<br>“Ньюсоник” ХХК болон Мэдээллийн технологийн төв хамтран тус системийг гаалийн дотоод серверт байршуулж, системийн ажиллагаа, процесс дараалал, системийн модуль зэргийн судалгааг хийсэн нь амжилттай болж, 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр eDoc системийг Гаалийн ерөнхий газарт туршилтаар ашиглаж эхэлсэн.<br>2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Гаалийн ерөнхий газарт 3 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>Сургалтад хамрагдсан албан хаагчдаас программд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг авч, нэгтгэн 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдөр “Ньюсоник” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, харилцан санал солилцсон.<br>Гаалийн ерөнхий газарт 2021 онд eDoc системийг бүрэн нэвтрүүлсэн.<br>-2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс eDoc системийг мөн Улаанбаатар хот дахь гаалийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын үйл ажиллагаанд туршилтаар ашиглаж эхэлсэн.<br>Албан хэрэг хөтлөлтийн eDoc цахим системийг харьяа гаалийн газар, хороодод нэвтрүүлэх ажлын хүрээнд систем ашиглах сургалтыг 2021 оны 09 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулсан.<br>Системийг ашиглах хэрэглэгчдийг эрхийн түвшнээр нь ангилж, 4 төрлийн сургалт орсон:<br>• Бичиг хэргийн эрхлэгчийн түвшний сургалтад 17 газар, хороодоос 16 бичиг хэргийн эрхлэгч, архивын эрхлэгч 19, албан хаагч болон удирдлага 89,<br>• Хүний нөөц болон системийн админы түвшний сургалтад 33, нийт 157 албан хаагч оролцов. Хэрэглэгчдийг видео заавар болон систем ашиглах гарын авлага, файлаар хангаж, системд нэвтрэх эрхийг үүсгэж өгсөн.<br>Албан хэрэг хөтлөлтийн eDoc системийн Android, IOS Аппликейшн нийлүүлэх гэрээг “Ньюсоник” ХХК-тай харилцан тохиролцож, талууд гарын үсэг зурж, хүчин төгөлдөр болсон.<br>Албан хэрэг хөтлөлтийн eDoc системийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд 100 хувь бүрэн нэвтрүүлж, 18 харьяа гаалийн газар, хороодтой албан бичиг солилцож эхэлсэн.<br>-Түр болон 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийг цахимжуулах ажлыг эхлүүлж, 10 хувьтай хийгдсэн байна.<br>2021 оноос цахим архив, албан хэрэг хөтлөлтийн программыг ашиглаж эхэлсэн бөгөөд ирсэн, явсан бичгийг “Цахим архив, албан хэрэг хөтлөлт”-ийн eDoc программаар давхар бүртгэж байгаа тул түр хадгалах хадгаламжийн нэгжийг цахимжуулах шаардлагагүй болсон. Харин 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн хувьд хадгаламжийн нэгжийг цахимжуулах ажил урьд өмнө нь хийгдэж байгаагүй бөгөөд 2022 оноос цахимжуулах ажлыг эхлүүлж, 185 хадгаламжийн нэгж байгаагаас 108 хадгаламжийн нэгжийг буюу 58,3 хувийг цахимжуулж, ARMC программд шивж оруулсан.<br>**Үнэлгээ: 100 хувь** |
| 5 | ЗОРИЛТ 4: Гаалийн | Гаалийн төв болон салбар | Хэрэгжилт, хувиар | 2020 он<br>Гаалийн төв | 2021 он<br>- Гаалийн төв | 1.Гаалийн төв лаборатори нь зориулалтын барилга байгууламжтай болж, шинжилгээний шинэ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | лабораторийг олон улсын жишигт нийцүүлэх | | лаборатори нь эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны зарим бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөх шаардлагатай бөгөөд дотоодын итгэмжлэлд хамрагдаагүй байна.<br>Гаалийн төв лабораторийн магадлан шинжилгээний үр дүн нь олон улсын итгэмжлэлд хамрагдаагүй тул олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй байна.<br>Гаалийн төв болон салбар лабораториудад ашиглагдах “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/ нэвтрүүлэх ажлын хэсэг 2020 оны 6 дугаар сард байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлаар УТҮГ ажлыг гүйцэтгэхээр болж, хийгдэх ажлын хөтөлбөрийг баталсан. | лабораторийн итгэмжлэлийн хүрээг /эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны зарим бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр/ өргөтгөж, дотоодын итгэмжлэлд хамрагдсан байна. Итгэмжлэлийн хүрээг 20-25 хувиар өргөтгөж, эрдэс, хүдрийн баяжмал, нүүрсэн бүтээгдэхүүнд сорилт, туршилт хийх эрхийг шинээр авсан байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.<br>- Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр Олон улсын итгэмжлэлд хамруулах ажлыг эхлүүлнэ. Хэрэгжилт 50 хувьтай байна.<br>- Олон улсад шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх ажлын хүрээнд Лондонгийн металлын биржид бүртгүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. Хэрэгжилт 25-30 хувьтай байна.<br>- Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлж | 74 тоног төхөөрөмжүүдийг суурилуулан ашиглалтад оруулснаар шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, 2021 оны 05 дугаар 27-28-ны өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төв (ҮИТ)-ийн үнэлгээнд хамрагдан, 6 дугаар сарын 28-ны өдрийн Техникийн хорооны хуралдаанаар орж, итгэмжлэлийн хүрээгээ уул уурхай, эрдэс түүхий эд, хүдэр баяжмалын үндсэн болон дагалдах элементүүдийн шинжилгээ, нүүрс болон газрын тосны бүтээгдэхүүний иж бүрэн шинжилгээний чиглэлээр өргөтгөж, ҮИТ-ийн даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/159 дүгээр тушаалаар сорилт шинжилгээ хийх итгэмжлэгдсэн лабораторийн эрхийн /ҮИТ, Гаалийн ерөнхий газрын хооронд/ итгэмжлэлийн гэрээг байгуулан өргөтгөж, итгэмжлэлийн эрхээ 4 жилийн хугацаатай сунган TL17 тоот гэрчилгээ гардан авсан.Ингэснээр итгэмжлэлийн хүрээг 20-25 хувиар өргөтгөж, сорилт, туршилт хийх эрхийг шинээр авч, төлөвлөгөөг 100% биелүүлж ажилласан байна.<br>2.Олон улсын итгэмжлэлд хамрагдах ажлын хүрээнд судалгаа хийсний үндсэн дээр БНХАУ-ын олон улсын итгэмжлэлийн үйлчилгээний (CNAS-China National Accreditation Service)-ээр ISO/IEC 17025 – 2017 стандартын дагуу олон улсын итгэмжлэлд хамрагдахаар болсон. Уг ажлын хүрээнд гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр зөвлөх үйлчилгээний багтай хамран БНХАУ-ын Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйлчилгээ (CNAS-China National Accreditation Service for conformity assessment)-д итгэмжлүүлэх өргөдлийг дагалдах бичиг баримтын хамт хятад хэл дээр орчуулан хүргүүлсэн ба шаардлагатай тайлбар, засвар оруулсан бичиг баримтыг мөн хятад хэл рүү орчуулан илгээж, гэрээний төслийг Гаалийн ерөнхий газрын дэд даргаар батлуулан олон улсын буухиа шуудангаар хүргүүлсэн.<br>3.Лондонгийн металлын биржид бүртгэлтэй дээжлэгч, шинжээч байгууллагаар бүртгүүлэхээр олон улсын итгэмжлэлд хамруулах зөвлөх үйлчилгээний багтай хамтран Лондонгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эхэлсэн байна. Хэрэгжилт 50 хувьтай байна.<br><br>2022 он<br>- Орхон аймаг дахь гаалийн газар болон Сайншанд дахь гаалийн газрын салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрсний, нефтийн чиглэлээр, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь салбар лабораторийг эрдсийн шинжилгээний чиглэлээр дотоодын итгэмжлэлд хамруулах ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 50-70 хувьтай байна.<br>- Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр олон улсын итгэмжлэлд хамруулах өргөдлийг хүргүүлж, холбогдох шалгалтад хамрагдсанаар Олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн эрх авсан байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.<br>- Олон улсад шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрүүлэх ажлын хүрээнд Лондонгийн металлын биржид бүртгүүлэх өргөдлийг хүргүүлсэн байна. Хэрэгжилт 50 хувьтай байна.<br>- Гаалийн лабораторийн тоног | металлын биржийн өргөдөл гаргагчдад зориулсан зааварчилгаа, шаардлагууд, асуулгын хуудас, гишүүн байгууллагатай байгуулах гэрээний төсөл зэргийг бэлтгэж ажилласан. Ажлын бэлтгэл төлөвлөгөөний дагуу бүрэн хангагдсан.<br>4.Лабораторийн мэдээллийн менежментийн систем (LIMS)-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд нүүрсний шинжилгээний хэсэгт нэвтрүүлсэн бөгөөд эрдсийн шинжилгээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Гаалийн төв лабораторийн нүүрсний шинжилгээний хэсгийн багаж тоног төхөөрөмжүүдийг LIMS системд холбож, сорилтын тайлангийн хуудсыг LIMS систем болон CAIS системтэй холбож, хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Лабораторийн программ (LIMS)-ыг нүүрсний шинжилгээний хэсэгт нэвтрүүлсэн бөгөөд эрдсийн шинжилгээнд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хანган ажиллаж байна.<br>5. Гаалийн шинэчлэлийн хүрээнд Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь гаалийн салбар лабораторийг эрдэс түүхий эд, нүүрсний, нефтийн чиглэлээр, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь салбар лабораторийг эрдсийн шинжилгээний чиглэлээр дотоодын итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. Үүнд:<br>-Тус салбар лабораториудад шинжээчийг 2022 оны 6 дугаар сард гаалийн ажилтныг бэлтгэх мэргэшүүлэх сургалтад хамруулж, тангараг өргүүлснээр шинжээч магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрхтэй болсон.<br>-Дээрх салбар лабораториудын MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу холбогдох 15 дотоод журмууд болон бүртгэлийн бичиг баримтуудыг боловсруулж, бүртгэл хөтлөн явуулж, итгэмжлэлийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>6. Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр олон улсын итгэмжлэлд хамруулах өргөдлийг хүргүүлсний дагуу БНХАУ-ын олон улсын итгэмжлэлийн үйлчилгээний (CNAS-China |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.<br>- Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь салбар лабораториудын үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн байна. Хэрэгжилт 50 хувьтай байна. | National Accreditation Service)-ээр ISO/IEC 17025 – 2017 стандартын дагуу олон улсын итгэмжлэх үйл ажиллагаа 2022 оны 10 дугаар сарын 16-19-ны өдрүүдэд шалгалтад эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр хамрагдсанаар Олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн эрх авсан. Үүнд:<br>-Эрдсийн шинжилгээ:<br>- Хайлуур жонш: CaF2 (титрийн шинжилгээний арга), P2O5 ба SiO2 (спектрофотометрийн шинжилгээний арга),<br>-Төмрийн хүдэр: нийт Fe (титрийн шинжилгээний арга), Ti, Cu, Ni, Co, Cr (индукцийн холбоост эмиссийн плазмын спектрометрийн арга),<br>-Зэсийн баяжмал: Cu (титрийн шинжилгээний арга), Ag (атом шингээлтийн спектрометрийн арга), Au (пробирын шинжилгээний арга), Mo (спектрофотометрийн шинжилгээний арга)<br>-Нүүрсний шинжилгээ: Илчлэг, аналитик чийг, дэгдэмхий бодисын гарц, үнслэг, барьцалдах чанар, хүхэр, фтор, хлор<br>-Нефтийн шинжилгээ:<br>-Авто бензин: ханасан уурын даралт, хувийн жин, зэс хавтгайн туршилт,<br>-Дизелийн түлш: хувийн жин, царцах температур, цетан индекс, хүхэр, найрлагын бүрэлдэхүүн, шүүгдэх хэм, нийт бохирдол, зэс хавтгайн туршилт, Агаарын хөлгийн түлш: хувийн жин, зэс хавтгайн туршилтын шинжилгээ хийж ажилласан.<br>7. Зөвлөх үйлчилгээний төслийн багаас Гаалийн төв лабораторийг ЛМБ-ийн дээжлэгч шинжээч байгууллагаар бүртгүүлэх ажлын хүрээнд Гаалийн төв лабораторийн үйл ажиллагааг тус байгуулагад танилцуулах, ЛМБ-ийн үйл ажиллагаатай танилцах, уулзалт хийх зэрэг ажлуудыг ЛМБ-ын гишүүнчлэл, бренд хариуцсан хэлтсийн зохицуулагч Кармелина Стаббс (Carmelina Stubbs)-тай хамтран, 2022 оны 10 дугаар сарын 24-26 өдрүүдэд Англи улсын Лондон хотноо болох “Металын биржийн 7 хоног” үйл ажиллагаанд Гаалийн ерөнхий газрын ажлын хэсэгтэй хамтран оролцсон. ЛМБ-ээс 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн албан бичгээр Монгол улс нь ЛМБ-ийн шаардлагыг бүхэлдээ хангаж чадахгүй байгаа тул |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЛМБ-д бүртгэлтэй дээжлэгч, Шинжлэгч байгууллагаар элсүүлэх өргөдлийг хүлээн авах боломжгүй гэсэн шийдвэрийг ирүүлсэн. Монгол Улсын металлын борлуулалтын хэмжээ ЛМБ-ын сонирхлыг татах хэмжээнд хүрсэн тохиолдолд энэ асуудлыг дахин тавих боломжтой гэсэн хариуг ирүүлсэн.<br>8. Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь салбар лабораториудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зөвлөх үйлчилгээний багтай хамтран ханган ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээний багийн гэрээний асуудал түр зогссон тул хүлээгдэж байгаа болно.<br>**Үнэлгээ 90 хувь** |
| 6 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>-Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад 29 албан хаагч, гаалийн хэргийн цахим сургалтад 382 албан хаагч, гадаад цахим сургалтад 8 албан хаагч, танхимын сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>-Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн 45 албан хаагчийг томилсон, 3 албан хаагчийг чөлөөлсөн, 1079 албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлсэн, 37 албан хаагчийг дэвшүүлсэн, 154 албан хаагчийг шагнаж урамшуулсан.<br>-Төрийн албан хаагчийн нийтлэг | 2021 он<br>-Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, баталсан байна.<br>-300 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна.<br>-Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>-Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна. | Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, баталсан байна.<br>Гаалийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалт, хөгжил гэсэн 3 чиглэлээр судалгаа хийж, Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийн төслийг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэйгээр боловсруулсан.<br>Төслийг Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд одоогоор шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байна.<br>600 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна.<br>2021-2022 онд дараах сургалтад 1383 албан хаагчийг хамруулсан байна. Үүнд: тул албан хаагчид нь үнэ төлбөргүй бүрэн хамрагдах байгууллага, харьяа газар, хороодыг ажилтнуудын үзлэгийн цагт зохицуулалт хийж дэмжиж ажиллаж байна.<br>Ковидийн үеийн халдвараар өвчилсөн албан хаагчдыг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан.Натур Мед Сэргээн засах төвд 25, Хос Шинэс сувилалд 50 нийт 75 албан хаагч хамрагдсан.<br>Гаалийн ерөнхий газрын 220 албан хаагчдын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Ажилтан, албан хаагчийн амьдарч буй байгууллагын эзэмшлийн орон сууцны засвар, үйлчилгээ хангалтгүй, сүүлийн жилүүдэд орон сууцны тоо нэмэгдээгүй. ЗГ-ын 2020 оны 185 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцжуулах хөтөлбөрт 21 албан хаагчийг хамруулсан. - Өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 42 албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж болгон 899,2 сая төгрөг олгосон. - 47 албан хаагчдад 19,7 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. - 3 албан хаагчийн ар гэрт 17.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон. - Хөдөлмөрийн чадвар алдсан 1 албан хаагчдад 5,1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон. -Төрийн албан | -Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулсан байна.<br>2022 он<br>-300 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна.<br>-Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>-Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна.<br>-Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулсан байна. | биеийн дархлааг сайжруулах, дэмжих зорилгоор витамин Д тарилгыг хийсэн.<br>Мөн Монос ХХК-тай хамтран ясны сийрэгжилт, амны хөндийн эрүүл мэнд, биеийн бодисын солилцооны зохицуулалтын шинжилгээнд 120 гаруй ажилчдыг хамруулсан.<br>Харьяа гаалийн газар, хороодоос нийслэл болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран нийт 754 албан хаагчдаа эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулсан.<br>-Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт хөтөлбөрийн дагуу Удирдлагын академиас зохион байгуулсан мэргэшүүлэх багц сургалт - 23 албан хаагч,<br>-Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн төвийн системд ажиллах чиглэлээр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 8 удаагийн цахим сургалт-112 албан хаагч /давхардсан тоогоор/,<br>-Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтсийн “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” цахим сургалт /2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн/- 100 албан хаагч,<br>-“Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл”, “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо” 2 өдрийн сургалт/ 2022 оны 02 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд/,<br>-Төрийн албаны зөвлөлийн Пүрэв гарагийн 19 удаагийн цахим сургалт-303 албан хаагч /давхардсан тоогоор/,<br>-Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл”, “Архинд донтох эмгэг” сургалт /2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн/ - 143 албан хаагч,<br>-"Авлига, түүний шалтгаан, нөхцөл, үр дагавар, авлигаас урьдчилан сэргийлэх зам” цахим сургалт - 602 албан хаагч,<br>-"Ард түмэнд үйлчлэх зарчим ба авлига, ашиг сонирхлын зөрчил" цахим сургалт - 100 албан хаагч.<br>Төрийн албаны чадахуйн зарчимд нийцүүлэн томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах ажлыг зохион |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар 99 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн боловч /COVID 19/ цар тахлын улмаас үзлэгт хамруулаагүй байна. | | байгуулсан байна.<br>Төрийн албаны зөвлөлийн Сангийн яамны дэргэдэх салбар зөвлөлөөс 2021-2022 онд 2 удаа сонгон шалгаруулалт зохион байгуулсан.Үүнд:<br>-Гаалийн ерөнхий газрын дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын 2021 оны 3 дугаар тогтоолын тусгай шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулснаас 18 иргэн хамрагдаж, шалгалтад тэнцсэн 14 иргэнийг томилсон.<br>-Төрийн албаны зөвлөлийн Сангийн яамны дэргэдэх салбар зөвлөлд 01/2998 албан бичгээр 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн захиалгын дагуу харьяа гаалийн газар, хорооны 9 удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг Гаалийн ерөнхий газарт 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, 14 иргэн оролцсоноос тэнцсэн 9 иргэнийг Сангийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 07, 10 дугаар тогтоолыг үндэслэн томилсон.<br>-Ковид-19 цар тахлын үед гаалийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор 362 албан хаагчийг шилжилт хөдөлгөөнд хамруулж, 3-6 сарын хугацаагаар 34 албан хаагчийг түр томилсон мөн албан тушаал ахисан 22, буурсан 13 албан хаагчийг томилсон байна.<br>-2021 оны Засгийн газрын хуралдаанаар Замын-Үүд боомтод үүсээд буй нөхцөл байдлыг сайжруулахаар хилийн хяналтын байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтнуудыг сэлгэн ажиллуулах хугацаатай үүрэг өгөгдсөний дагуу 113 албан тушаалтныг чөлөөлж, томилж шийдвэрлэсэн байна. 2022 онд гаалийн байгууллагад шинээр ажилд томилсон 65, сэлгэн ажиллуулсан 78, ажлын туршлага, мэдлэг, ур чадварыг харгалзан албан тушаал дэвшүүлсэн 56, албан тушаал буурсан 39 албан хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн бол 2022 оны Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 12 албан тушаалтныг албан тушаал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буурuулсан. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д заасны дагуу гаалийн байгууллагаас төрийн өөр байгууллагад шилжсэн 4 албан хаагч байна.<br>-Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үндэслэлээр, 43 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалд 38 удирдах албан тушаалтан ажиллаж байна.<br>-Тайлант хугацаанд 1173 албан хаагч шагнагдсанаас төрийн дээд одон, медалиар 80, Гаалийн ерөнхий газрын шагналаар 477, бусад байгууллагын шагналаар 616 албан хаагч тус тус шагнагдсан байна.<br>Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлэх<br>2021-2022 онд өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 94 албан хаагчдад 2.24 тэрбум төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, ар гэрийн гачигдал тохиолдсон 108 албан хаагчдад 46.3 сая төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан 10 албан хаагчийн ар гэрт 90.6 сая төгрөг, 2 албан хаагчид 2.5 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 80 албан хаагчид 46.1 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож шийдвэрлэсэн. Ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулахаар нийт 4 харьяа газрын ажилчдын орон сууцны засвар, үйлчилгээнд 482,6 сая төгрөг, албан хаагчийн тээврийн хэрэгсэл, ачаа тээшний зардалд 2.3 сая төгрөг олгож шийдвэрлэсэн.<br>“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 1997 оны 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэж, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Албан тушаалын сарын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” Б/342 дугаар тушаалыг батлуулж, төрийн үйлчилгээний 397, төрийн тусгай 155 нийт 552 албан хаагчдад олгосон. “ГУБ-ийн цолны нэмэгдэл олгох тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/1039 тушаалаар нийт 700 гаруй албан хаагчдад гаалийн итгэмжит зөвлөх, зөвлөх цолны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдлийг олгож шийдвэрлэв.<br>“Төрийн албан хаагчид докторын, профессор цолны нэмэгдэл олгох журам”-ын дагуу 9 доктор, 2 профессорт эрдмийн цолны нэмэгдэл, 9 албан хаагчид төрийн үйлчилгээний мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгож байна.<br>2021-2022 онд Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 08 сарын 04-ний өдрийн “Гаалийн улсын байцаагчийн эрхийн баталгааг хангах тухай” А/173 дугаар тушаалаар хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөхөөр шийдвэрлэсэн нь Замын-Үүд дэх гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газарт хэрэгжиж байна.<br>Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулсан байна.<br>Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсантай холбогдуулан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сувилалд хамруулах зардалд хэмнэлт хийсэн.<br>Эрүүл мэндийн яамнаас Бүх нийтийн эрт илрүүлгийн үзлэг оношилгоог зохион байгуулах болсон.<br>**Үнэлгээ: 90 хувь** |
| 7 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Гааль судлалыг хөгжүүлэх | Хэрэгжилт, хувиар | 2020 он “Гааль судлал-2” эмхэтгэлд оруулах гаалийн улсын байцаагчийн судалгааны болон хэвлэлийн эх бэлтгэх ажлын хэрэгжилт 50 хувьтай байна. | 2021 он<br>-Гааль судлалыг хөгжүүлэх, судалгааны арга зүйн чиглэлээр 4 жилийн хөтөлбөр боловсруулан батална.<br>-Гаалийн хэргийн чиглэлээр судалгаа хийж, үр дүнг “Гааль” сэтгүүлд нийтлэн гаалийн улсын байцаагч нарт хүргэнэ.<br>-“Гааль судлал-2” эмхэтгэлийг нэгтгэн | "Гааль судлалын хүрээнд Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодоос хийж хэрэгжүүлэх ажлын санал авч нэгтгэн, “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024 хөтөлбөр” – ийн төслийг боловсруулж, батлуулсан.<br>- “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024 хөтөлбөр”-ийн дагуу Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдын 2012-2022 оны хугацаанд хийсэн доктор /Ph.D/, магистрын бүтээл, эрдэм шинжилгээний илтгэл, эрдэмтэн судлаачидтай хамтарсан бүтээл, судалгаа шинжилгээний ажлын хураангуйг авч, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэвлүүлнэ.<br>-4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилт 25 хувьд хүрсэн байна.<br>2022 он<br>-Гааль судлалын чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний ажил, ном, бүтээлийн нэгдсэн сан үүсгэнэ.<br>-Гааль судлалын чиглэлээр мэргэшсэн судлаачдыг чадавхжуулж, туршлага судална, судалгаа хийх материаллаг бааз, программ хангамжийг бүрдүүлнэ.<br>-4 жилийн хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна. | “Гааль судлал-2” эмхэтгэлд оруулахаар ажиллаж байгаа бөгөөд цаашид материалаа эмхэтгэх, дизайн, хэвлэлийн эх бэлтгэх ажил хийгдэнэ. Эмхэтгэлд Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдаас 21 бүтээл, “Гаалийн хөгжлийн чиг хандлага” олон улсын онол, практикийн бага хурлаас шалгарсан 16 бүтээл, нийт 37 бүтээл одоогоор цугларсан байна.<br>Мөн Л.Минжин, Т.Лхагваа, Б.Баттөмөр, С.Цэцгээ, Ж.Чимгээ зэрэг ахмад гаальчид бүтээлээ өгөхөөр тохиролцсон. Эмхэтгэл “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024 хөтөлбөр”-ийн дагуу 2023 оны I улиралд хийгдэж дуусахаар төлөвлөгдсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу эмхэтгэлийг хэвлүүлэх санхүүгийн боломж хязгаарлагдсан тохиолдолд цахим хувилбарыг судалж байна.<br>-“Гааль судлал-2” эмхэтгэлд орох боломжтой “Гааль” сэтгүүлүүдэд нийтлэгдсэн өгүүллүүдийн дүн шинжилгээг хийсэн. “Гааль” сэтгүүл нь 2009 онд анх хэвлэгдэж эхэлснээс хойш нийтдээ 20 дугаар гарсан байна. Сэтгүүлийн дугаар бүрт гаалийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын бакалавр, магистр, докторын түвшинд хийсэн судалгааны ажил болон шинээр сонирхон судалж байгаа сэдвийн хүрээнд өгүүлэл нийтлүүлж, нийт албан хаагчдын хүртээл болгодог уламжлалтай. Эдгээр сэдвийн хүрээнд нийт 91 эрдэм шинжилгээний өгүүлэл болон нийтлэл албан хаагчдын хүртээл болжээ. Хэвлэгдэж гарсан бүтээлүүдээс 17 нь эрдэм шинжилгээний өгүүлэл буюу магистр, докторын түвшний судалгааны ажил юм.<br>- Гааль судлалын чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний ажил, ном, бүтээлийн нэгдсэн сан үүсгэх ажлын хүрээнд дараах дөрвөн чиглэлээр материал цуглуулж байна. Үүнд:<br>1. “Гааль судлал-1 /2002-2011/” эмхэтгэлд орсон материал<br>2. “Гааль судлал-2 /2012-2022/” эмхэтгэлд орох материал<br>3. “Гаалийн хөгжлийн чиг хандлага” олон улсын онол, практикийн бага хурлын хүрээнд шалгарсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээл<br>4. “Гааль” сэтгүүлүүдэд нийтлэгдсэн материал /2009-2022 он/.<br>Энэхүү ажил нь “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024 хөтөлбөр”-ийн дагуу 2022-2024 онд хийгдэх ёстой бөгөөд ажлын гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна.<br>- “Гааль судлалыг хөгжүүлэх 2021-2024 хөтөлбөр”-ийн дагуу гаалийн байгууллага үүсэж хөгжсөний 110 жилийн ой угтсан арга хэмжээний хүрээнд түүхч, доктор Г.Дашням, Төрийн захиргааны удирдлагын газрын гаалийн улсын байцаагч Д.Чулуунцэцэг нар “Монгол Улсын гаалийн байгууллагын түүхэнд холбогдох баримт бичгүүд 2011-2021 он” номын архивын баримт бүрдүүлэх, хэвлэлийн эх бэлтгэх ажлыг гүйцэтгэж, хэвлэлтэд шилжүүлсэн.<br>Хөтөлбөрийн нэг хэсэг болох гааль судлалын чиглэлээр мэргэшсэн судлаачдыг чадавхжуулж, туршлага судлах ажлын хүрээнд:<br>- Монгол Улсад шинэ үеийн гаалийн байгууллага үүсэж, хөгжсөний 110 жилийн ойг угтан “Гаалийн хөгжлийн чиг хандлага” олон улсын онол практикийн бага хурлыг “Гааль-Бизнес түншлэлийн төв” ТББ-тай хамтран 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Тус бага хуралд НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал, ДГБ-д манай байгууллагыг төлөөлөн ажиллаж байгаа эксперт, МУИС, ДХИС, гаалийн байгууллагын төлөөллөөс нийт 7 илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Бага хуралд хамтарсан болон бие даасан хэлбэрээр монгол хэл дээр 16, англи хэл дээр 3, нийт 19 бүтээл, 3 илтгэлийг оролцогчдоос ирүүлсэн бөгөөд профессор, доктор зэрэгтэй судлаач болон бакалавр, магистр зэрэгтэй судлаач, гаалийн албан хаагч гэсэн 2 ангиллаар дүгнэж, шалгаруулсан.<br>- Гааль судлалын хүрээнд “Шинэ үеийн гаалийн байгууллага үүсэж хөгжсөний 110 жилийн ой”-г угтаж тус төвөөс гаалийн байгууллагын ахмад, залуу үеийн уулзалт арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Дэд дарга Г.Энхтайван уулзалтыг нээж, хүндэт зочноор |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцсон Гаалийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан, нийгмийн ухааны доктор, профессор Т.Лхагваа “Гаалийн байгууллагын түүхэн замнал, уламжлал”, ахмад багш, гаалийн итгэмжит зөвлөх Ж.Булган “Гаалийн байгууллагын үйлчилгээ”, МУИС-ын профессор Н.Батнасан “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн стратеги бодлого ба гаалийн хөгжил, хандлага”, гаалийн итгэмжит зөвлөх Д.Довчинсүрэн “Гаалийн улсын байцаагчийн ёс зүй, төлөвшил” сэдвээр тус тус илтгэл тавьж, залуу гаальчид сонирхсон асуултаа асууж, харилцан ярилцсан. Уулзалтад гаалийн залуу үеийг төлөөлж, 60 гаруй гаалийн улсын байцаагч, албан хаагчид оролцсон.<br>- “Гааль судлалын хөтөлбөр”-ийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Судалгаа, шинжилгээ хийх ерөнхий арга зүй гаалийн үйл ажиллагаатай холбогдох нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетинг, худалдааны тэнхимийн профессор Н.Батнасан(Ph.D) “Судалгаа шинжилгээний ажлыг хийх арга зүй”, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч доктор, дэд профессор Б.Цэндсүрэн “Эрсдэлийн ялгаатай загвар гаалийн хяналтад: Монголын гаалийн жишээн дээр”, Хэвлэл мэдээлэл сургалт судалгааны төвийн гаалийн улсын байцаагч багш доктор, дэд профессор Д.Даваасүрэн “Гаалийн байгууллагын хүний нөөцийн удирдлагыг судлах судалгааны арга” сэдвээр тус тус илтгэл тавьсан. Тус сургалтад нийт 70 албан хаагч болон харьяа гаалийн газар, хорооны 30 гаруй албан хаагч цахимаар хамрагдсан.<br>**Үнэлгээ 100 хувь** |
| 8 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээг жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах, | Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр | 2020 он<br>-“Гаалийн байгууллагын 2016-2020 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжих хугацаа 2020 онд дууссан.<br>- Гаалийн байгууллагын 2019 оны үйл ажиллагааны үнэлгээ 90 хувь буюу “Маш сайн”. | 2021- 2022 он<br>-Стратеги төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөн, эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавин, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнана. | 1.“Гаалийн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г /43 арга хэмжээ бүхий/ Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу боловсруулж, Монгол Улсын Сангийн Сайд Б.Жавхланд хүргүүлж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Гаалийн байгууллагын 2021 оны эхний хагас |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах, дүгнүүлэх | | | -Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.<br>-Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг “А” үнэлгээгээр дүгнүүлсэн байна. | жилийн болон жилийн эцсийн эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн. “Гаалийн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г /43 арга хэмжээ бүхий/ Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу боловсруулж, Монгол Улсын Сангийн Сайд Б.Жавхланд хүргүүлж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.<br>Гаалийн байгууллагын 2022 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>2.Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2022 явцын хяналт шинжилгээ хийхэд 4 зорилтын хүрээнд 36 хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөсөн байсан. Эдгээрээс төлөвлөсөн хугацаагаар авч үзвэл:<br>2021 онд хэрэгжиж дуусах 2, 2022 онд хэрэгжиж дуусах 3 хөтөлбөр, арга хэмжээ,<br>2021 онд хэрэгжих 2 хөтөлбөр, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан бөгөөд 91 хувийн дундаж үнэлгээтэй хэрэгжсэн байна.<br>2022 онд хэрэгжих 3 хөтөлбөр, арга хэмжээ нь 2021-2022 оны эхний хагас жилийн байдлаар 97 хувийн гүйцэтгэлтэй үнэлгдсэн байна. Эдгээр 3 хөтөлбөр арга хэмжээ нь 2022 оны жилийн эцэст бүрэн байхаар төлөвлөгдсөн. 2023 оны эхний улиралд 2021 он, 2022 оны гүйцэтгэлд дахин хяналт шинжилгээ үнэлгээ хийхээр төлөвлөсөн. 2022 онд явцын хяналт шинжилгээ хийхэд тус онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ажлуудын хэрэгжүүлж дуусах хугацаа болоогүй байсан болно.<br><br>3.Сангийн яамнаас ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2018 оны 143 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тушаалаар баталсан “Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу Гаалийн ерөнхий газрын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 87.2 оноо буюу 88.7 хувийн биелэлттэйгээр “Сайн” гэж үнэлэгдсэн. Гаалийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тушаалаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу мэдээ, тайланг хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2022 оны эхний хагас жилийн үнэлгээг ирүүлээгүй байна. **Үнэлгээ: 100 хувь** |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих; | | | | | | |
| 9 | ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх, | Шуурхай удирдлагын төвийг гаалийн хяналт, шалгалтад үр бүтээлтэй ашиглах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр Зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн системийг ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар, Илрүүлж, шийдвэрлэсэн зөрчилд нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүн, | 2020 он<br>Шуурхай удирдлагын төвийн байр ашиглалтад орж, 14 харьяа гаалийн газар, хороодод телекамер суурилуулсан. | 2021 он<br>-Харьяа гаалийн 4 газар, хороодод телекамерийг бүрэн суурилуулж, гаалийн байгууллагын Шуурхай удирдлагын төв, телехяналтын системийг бүрэн ашиглалтад оруулсан байна.<br>-Шуурхай удирдлагын төвийг ашиглан гаалийн хяналт, шалгалтад эрсдэл тооцон, зөрчил илрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.<br><br>2022 он<br>-Шуурхай удирдлагын төвийг ашиглан гаалийн хяналт, шалгалтад эрсдэл тооцон зөрчил илрүүлсэн байна.<br>-Төрийн бусад байгууллагуудтай хамтран | 1. Гаалийн ерөнхий газрын Шуурхай хяналт, удирдлагын төв нь 18 харьяа гаалийн газар, хорооны байнгын үйл ажиллагаатай 20 хилийн боомт, 108 гаалийн хяналтын бүс, 86 гаалийн баталгаат бүс, 56 гаалийн баталгаат агуулах, 4 гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар, 3 гаалийн баталгаат үйлдвэрийн газар, 24 татваргүй барааны дэлгүүр, 1 тусгай бүс, 3 чөлөөт бүсэд хяналтын камераар, гаалийн мэдээллийн автоматжуулсан системээр хяналт тавьж ажиллаж байна. Мөн харьяа гаалийн газар, хороодын дэд төвөөр дамжуулан гаалийн байгууллагын 510 хяналтын камер, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн 1470 хяналтын камер нийт 1980 хяналтын камераар зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдамж, чиглэлээр хангаж ажиллаж байна. Шуурхай хяналт, удирдлагын төвийн камерын системд 10 оператор ажиллаж, хяналтын 55 инчийн 60 дэлгэц, зорчигчийн царай таних 22 камер, тээврийн хэрэгслийн дугаар таних 68 камер, эрсдэлтэй зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг таньж, удирдлагын дэлгэц рүү |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төгрөгөөр | | хууль сахиулах үйл ажиллагаанд үр бүтээлтэй ашиглаж эхэлсэн байна. | анхааруулах ухаалаг онилгооны системийг иж бүрэн ашиглахаар төлөвлөж байна.<br><br>2. Шуурхай хяналт, удирдлагын төвөөс гаалийн хяналт, шалгалтад эрсдэл тооцон, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар болон Ховд аймгийн Булган дах гаалийн газрын хяналтын бүсүүдэд бүрдүүлэлт хийсэн нийт 26 гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, тухайн газар, хороодын зөрчил, хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нартай хамтран дахин шалгалт хийснээр гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй байсан 15 зөрчлийг илрүүлэн зөрчлийн арга хэмжээ авч, 97,205,247.44 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 48,602,623.69 төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна.<br><br>3. Шуурхай хяналт, удирдлагын төвийн камерын хяналтыг төрийн бусад байгууллагуудтай хамтран хууль сахиулах үйл ажиллагаанд үр бүтээлтэй ашиглаж байна. Энэ чиглэлээр “Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын хяналт, шалгалт хийж буй бичлэгийг хуулбарлан ирүүлэх тухай” АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 06/16116 албан бичгийн дагуу дээрх газрын бичлэгийг хуулбарлан, хариуг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01-12/3402 албан бичгээр хүргүүлсэн.<br>**Үнэлгээ: 100 хувь** |
| 10 | ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах, | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | 2020 он<br>-Гаалийн бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд эрсдэл тооцож чадахгүй байна. Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд эрсдэл тооцох арга, аргачлалыг боловсруулан ажиллаж байна. Хэрэгжилт 20 хувьтай байна.<br>-Бүрдүүлэлтийн үе шат: CAIS (RM) нь эрсдэлийн сонгон шалгах | 2021 он<br>-Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд эрсдэл тооцох арга, аргачлалыг боловсруулсан байна.<br>-Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн найруулж баталсан байна.<br>-Бичиг баримтын болон | "1.Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд эрсдэл тооцох аргачлал, программын шийдэл боловсруулахын тулд бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд экспортлогч орны гаалийн байгууллагаас экспортын мэдээллийг тухайн ачилт ирэхээс өмнө хүлээн авах тогтолцоо бүрдээгүй байгаа тул 2023 оноос гаалийн бүрдүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр төлөвлөж ажиллаж байна. Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд мэдээлэл авах тогтолцоог бүрдүүлэх, гаалийн мэдүүлэг, рентген зураг солилцох чиглэлээр Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон ОХУ-ын Гаалийн алба хоорондын Эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | программыг ашиглаж, гаалийн бүрдүүлэлтийн үе шатанд эрсдэл тооцож, ажиллаж байна. 2020 оны байдлаар импортын гаалийн бүрдүүлэлтэд ээлэх улаан төлөв 86%, улбар шар төлөв 13%, ногоон төлөв 1%, экспортын гаалийн бүрдүүлэлтэд ээлэх улаан төлөв 21%, улбар шар төлөв 40 %, ногоон төлөв 39% байна. Нийт гаалийн бүрдүүлэлтийн тоо 611792 улаан төлөв 44%, улбар шар төлөв 30%, ногоон төлөв 26% байна. Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь өмнөх оны мөн үеэс 1%-аар буурсан. Хэрэгжилт 55.56 хувьтай байна.<br>-Гаалийн хорио цээрийн хяналтад БТКУС-ын 8 орны түвшний 2531 барааг их, дунд, бага эрсдэлээр ангилан хяналт тавьж байна.<br>-Бүрдүүлэлтийн дараах үе шатанд аудитад суурилсан бичиг баримтын шалгалтыг хийж байна. 2020 онд эрсдэл тооцсоны үр дүнд 55 ААН-ийг бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулах саналыг хүргүүлсэн. Үүнээс: 50%-д ААН-д Бүрдүүлэлтийн дараах шалгалт хийгдсэн байна.<br>Хэрэгжилт 20% - | бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хэмжээг 5 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд “Эрсдэлтэй зорчигчийг онилох систем”-ийн хөгжүүлэлтийг хийсэн байна.<br>-Мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын программын хөгжүүлэлтийг хийсэн байна.<br>-Аж ахуйн нэгжийн хууль сахилтын түвшинг тодорхойлж, сайжруулах зорилгоор эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтын тоог өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлсэн байна.<br>2022 он<br>-Бүрдүүлэлтийн өмнөх үе шатанд бараа ирэхээс өмнө эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэх, программын шийдлийг гаргасан байна.<br>-ОХУ-тай солилцох гаалийн мэдүүлэг, рентген зураг, БНХАУ-тай солилцох манифестад /төмөр замын, агаарын, шуудангийн, автотээврийн төрлөөр/ эрсдэл тооцож эхэлсэн байна.<br>-Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас | боловсруулж, ажлын албаны цахим уулзалтыг зохион байгуулан, хэлэлцээрийн төсөлд хоёр орны гаалийн байгууллагын удирдлага гарын үсэг зурахад бэлэн болгосон. БНХАУ-тай солилцох манифестад /төмөр замын, агаарын, шуудангийн, автотээврийн төрлөөр/ эрсдэл тооцох чиглэлд БНХАУ, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын эрсдэлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах хэлэлцээрийн төсөл боловсруулан, харилцан солилцож, 2023 онд болох Холбоо баригч нарын уулзалтаар эцэслэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>**Үнэлгээ: 30 хувь**<br><br>2. Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд дараах бодлогын бичиг баримтуудыг боловсруулж, батлуулсан. Үүнд:<br>-Гаалийн тухай хуулийн шинэчлэн найруулах төсөлд ""Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” болон “Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх” асуудлаар шинэ бүлэг, зүйл заалтыг олон улсын стандарт, гэрээ, конвенцид нийцүүлэн боловсруулж оруулсан.<br>-2011 оны 87 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хяналтын стратеги”-ийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан цаашид сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсэж, өөрчлөгдөн хувьсаж буй олон улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдал, худалдаанд тулгарч байгаа хүндрэлтэй асуудал, шинээр гарч ирж буй саад тотгорт үр дүнтэй хариу арга хэмжээ авах хэрэгцээ шаардлагын улмаас “Гаалийн хяналтын стратеги”-ийг шинэчлэн, боловсруулж, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/343 дугаар тушаалаар батлагдсан.<br>**Үнэлгээ:100 хувь**<br><br>3. Гаалийн хяналтын тогтолцоонд хууль сахилтыг дэмжих чиглэлд эрх зүйн чадамжийг нэмэгдүүлэх зарчмын өөрчлөлтийг авч ирсэн “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”- |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тай байна.<br>2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ГЕГ-ын даргын А/287 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх” журмыг мөрдөж байна.<br>Агаарын тээврийн зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож байна. Авто болон төмөр замаар зорчих зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцох тогтолцоо бүрдээгүй байна. Хэрэгжилт 20 хувьтай байна. | чөлөөлөх хувь хэмжээг 7 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Бүрдүүлэлтийн дараах шалгалтаар зөрчил илрээгүй, хууль сахилт сайн гэж үнэлэгдсэн аж ахуйн нэгжийг дэмжиж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулсан, бүрдүүлэлтийн дараах шалгалтын тогтолцоог боловсронгуй болгосон байна. | ыг боловсруулж, Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/148 дугаар тушаалаар батлагдсан. Уг журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд орсноор албан ёсоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Гаалийн байгууллага 2022 оны байдлаар 649479 гаалийн бүрдүүлэлт хийсэн нь 2020 онтой харьцуулбал 2 %-иар буурсан үзүүлэлттэй байгаа боловч импортын гаалийн бүрдүүлэлт 300028 буюу 20%-иар, экспортын гаалийн бүрдүүлэлт 349479 буюу 20%-иар буурсан. Импортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд гаалийн хяналт шалгалтад хамрагдсан гаалийн бүрдүүлэлт тоо 82%-тай, бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдсөн гаалийн бүрдүүлэлт 18%-тай байгаа нь 2020 онтой харьцуулахад нийт бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь 4%-аар өссөн үзүүлэлттэй байна. Бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээг зорилтод хувь хэмжээнд 7 хувьд хүрээгүй шалтгаан нь өнгөрсөн 2 жилд импортын гаалийн бүрдүүлэлт 20-р өссөн, экспортын гаалийн бүрдүүлэлт 20-р буурсан нөхцөл байдал, мөн хорио цээрийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбогдуулан “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай” хуулийн дагуу гаалийн хяналтад хорио цээрийн хяналтын зорилгоор шалгах барааны тоо 30%-нэмэгдсэн зэрэг нь гаалийн хяналт, шалгалтаас чөлөөлөгдөх гаалийн бүрдүүлэлтийн хувь хэмжээнд нөлөөлсөн байна.<br>**Үнэлгээ: 90 хувь**<br><br>4.Төмөр зам болон автозамын тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд УБТЗ-тай уулзалт хийж, улсын хилээр нэвтрэх вагоны мэдээллийг хүлээн авч, гаалийн хяналт, шалгалтад ашиглаж программ хангамжийг боловсруулж, бэлэн болгосон. Хэрэгжилтэд дараах хүндрэлтэй асуудал тулгарч байна: |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -УБТЗ-ын мэдээлэл илгээх сервис нь зарим тохиолдолд мэдээлэл зөрүүтэй дамжуулж байна. Энэхүү системийн хэрэгжилтийг сайжруулсны дараа төмөр замаар зорчих зорчигчийн мэдээллийг тест хэлбэрээр хүлээн авч, CAIS системд бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахаар болсон. Автозамаар зорчих зорчигчийн мэдээлэлд үндэслэн гаалийн бүх газар, хороод өөрсдийн боловсруулсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн эрсдэлтэй зорчигчийн мэдээллийн программ ашиглан эрсдэл тооцох боломж бүрдсэн.<br>**Үнэлгээ: 50 хувь**<br><br>5.Татварын ерөнхий газар болон Гаалийн ерөнхий газрын Гаалийн эрсдэлийн удирдлагын газарт нийт 480 аж ахуйн нэгжийн эрсдэлийн дотоод судалгааг хийж, хүргүүлсэн. Хоёр байгууллагын эрсдэлийн шалгуурын дагуу зэрэгцүүлэлтээр нийт 51 аж ахуйн нэгжид Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн. RIBS төслийн хүрээнд Бүрдүүлэлтийн дараах шалгалтын хөгжүүлэлтийг хийснээр, гаалийн улсын байцаагч нарын боловсруулах бичиг баримтууд бүрэн цахимжсан.<br>2022 онд бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн 45 аж ахуйн нэгжийн шалгалтын үр дүнг судалж, шалгалтаар зөрчил илрээгүй 25 компанийн үр дүнгийн судалгааг хийж, CAIS системийн санд оруулсан. Гаалийн эрсдэлийн удирдлагын газрын Эрсдэлийн удирдлагын программын хууль сахилтын түвшин өндөр гэсэн заавал шалгах шалгуурт оруулах 3 компанийн мэдээллийг Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>**Үнэлгээ: 100 хувь**<br><br>**Дундаж үнэлгээ: 74 хувь** |
| 11 | ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй | Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгон, | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр Гаалийн хяналт, бүрдүүлэл тэд | 2020 он<br>2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаагаар:<br>1.АВТО - ИМПОРТ<br>1.1. Хилийн боомт болон гүний терминалын цагийг | 2021 он<br>-Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах судалгаанд дүн шинжилгээ хийсэн байна.<br>-Дүн шинжилгээнд үндэслэн бүрдүүлэлтийн | "Гаалийн байгууллага бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг 2010 оноос хойш 2 жил тутамд хийж байсан бөгөөд 2012 оны судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай хийсэн. Сүүлийн судалгааг 2019-2020 онд Дэлхийн банк группын гишүүн Олон улсын санхүүгийн корпорацын “Худалдааг хөнгөвчлөх, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг хамгаалах, | бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах | зарцуулах хугацаа, хувиар Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | багтаасан дундаж хугацаа - 3 өдөр 12 цаг 7 минут;<br>1.1.1.Алтанбулаг хилийн боомт – Монгол Транс терминал - 6 өдөр 15 цаг 7 минут;<br>1.1.2.Замын-Үүд хилийн боомт – Монгол Транс терминал - 3 өдөр 1 цаг 12 минут;<br>1.2. Хилийн боомт дээрх дундаж хугацаа (хил дээр олгосон) 16 цаг 52 минут;<br>1.2.1.Замын-Үүд хилийн боомт - 18 цаг 25 минут;<br>1.2.2.Алтанбулаг хилийн боомт -7 цаг 50 минут;<br>1.2.3.Цагааннуур хилийн боомт - 6 цаг 23 минут;<br>1.3. Гүний терминалын нийт дундаж хугацаа (Монгол Транс гүний терминалд эзэнд нь олгосон) - 1 өдөр 2 цаг 58 минут;<br>2.АВТО - ЭКСПОРТ<br>2.1. Хилийн боомтоос гаргах экспортын дундаж хугацаа - 5 цаг 20 минут;<br>2.1.1.Цагааннуур хилийн боомтоос гаргах экспорт - 2 цаг 26 минут;<br>2.1.2. Замын-Үүд хилийн боомтоос гаргах экспорт - 5 цаг 27 минут;<br>2.2. Гүний терминалаас ачигдсан экспортын бараанд хилийн боомтод зарцуулсан дундаж хугацаа - 6 цаг 14 минут;<br>2.3. Авто замаарх “захиалга дуудлага” –н экспортын гүний терминалын дундаж | цаг хугацааг бууруулах төлөвлөгөөг боловсруулсан байна.<br>2022 он<br>-2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах төлөвлөгөөний биелэлтийн 30 хүртэлх хувийг хэрэгжүүлнэ. | хөдөө аж ахуйн экспортын өрсөлдөх чадвар” төслийн туслалцаатайгаар ДГБ-ын арга зүй, зааварчилгаа, болон мэдээлэл боловсруулах программд тулгуурлан хийлгэж, тайланг 2020 оны 11 дүгээр сард хүлээн авсан. Тайланд үндэслээд Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчинг сайжруулах, худалдааг хөнгөвчлөхийн тулд шийдвэрлэх шаардлагатай зөвлөмжүүдийг гадаад худалдаанд оролцогч нар болон төрийн хяналт хэрэгжүүлж байгаа байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх зөвлөмжийн биелэлтийг хангуулах зорилгоор “Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан-2019”-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан, Гаалийн ерөнхий газрын дэд даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар харуулбал:<br>1.Гаалийн хяналт, шалгалтын газраас хэрэгжүүлсэн 3 арга хэмжээний биелэлт 88 хувь;<br>2.Гаалийн бүрдүүлэлтийн газраас хэрэгжүүлсэн 6 арга хэмжээний биелэлт 98;<br>3.Гаалийн эрсдэлийн удирдлагын газраас хэрэгжүүлсэн 4 арга хэмжээний биелэлт 100;<br>4.Гаалийн хорио цээрийн газраас хэрэгжүүлсэн 2 арга хэмжээний биелэлт 100;<br>5.Хуулийн хэлтсээс хэрэгжүүлсэн 2 арга хэмжээний биелэлт 100;<br>6.Мэдээллийн технологийн төвөөс хэрэгжүүлсэн 10 арга хэмжээний биелэлт 100;<br>7.Хэвлэл мэдээлэл, сургалт, судалгааны төвөөс хэрэгжүүлсэн 2 арга хэмжээний биелэлт 98;<br>8.Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас хэрэгжүүлсэн 4 арга хэмжээний биелэлт 99;<br>9.Гаалийн төв лабораториос хэрэгжүүлсэн 3 арга хэмжээний биелэлт 80 буюу нийт 95.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br><br>2022 онд Cims.gaali.mn системийн цаг хугацааны хэмжилтийн программын туршилтыг хийж, программыг сайжруулах санал боловсруулан Аствишн ХХК-ийн ажилтнуудад дараах саналыг хүргүүлэн программд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хамтран ажилласан:<br>-Хасах тооцоолoлтой, улаан, улбар шар төлөвт 0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хугацаа - 2 өдөр 12 цаг 37 минут;<br>3.ТӨМӨР ЗАМ - ИМПОРТ<br>3.1. Хилийн боомт ба гүний терминалыг багтаасан дундаж хугацаа (АБТЭМА) - 4 өдөр 20 цаг 10 минут;<br>3.1.1. Замын-Үүд – АБТЭМА - 4 өдөр 16 цаг 18 минут;<br>3.1.2. Сүхбаатар – АБТЭМА - 5 өдөр 19 минут;<br>3.2. Хилийн боомт дахь дундаж хугацаа - 1 өдөр 2 цаг 57 минут;<br>3.2.1. Замын-Үүд хилийн боомт - 1 өдөр 13 цаг 26 минут;<br>3.2.2. Сүхбаатар хилийн боомт - 14 цаг 28 минут;<br>3.3. АБТЭМА гүний терминалд дундаж хугацаа - 2 өдөр 5 цаг 51 минут;<br>3.3.1. Замын-Үүд өртөөнөөс төмөр замаар - 2 өдөр 9 минут;<br>3.3.2. Сүхбаатар өртөөнөөс төмөр замаар - 2 өдөр 16 цаг 47 минут;<br>4. ШИЛЖҮҮЛЭН АЧИЛТ ХИЙГДЭЖ АВТОМАШИНААР ОРЖ ИРСЭН ЧИНГЭЛЭГ ТӨМӨР ЗАМААР ШИЛЖҮҮЛЭН ТӨМӨР ЗАМААР ШИЛЖҮҮЛЭН АЧИГДАХ – ХИЛИЙН БООМТ<br>4.1. Хилийн боомт гүний терминалын цагийг багтаасан дундаж хугацаа | | тооцоолoлтой цаг хугацааны алдааг олж, засварлах;<br>-Засварт буцаасан тоог гаргах;<br>-Жагсаалтын хайлтын талбарууд, цаг хугацааны тооцооллын талбарт тоон үзүүлэлтийн интервалаар сонголт хийж тооцоолох боломжтой болгох;<br>-Үр дүнгийн pdf файл дээр боловсруулалт хийхээр сонгосон үзүүлэлтүүдийг маягтаар гаргах, pdf файл гаргах үзүүлэлтүүдэд гарчиг, мэдээлэл, тайлбар нэмж оруулах боломжтой болгох;<br>-Хорио цээрийн ГУБ-ийн хугацааны тооцооллыг нэмэх;<br>-Мэдүүлгийн дэлгэрэнгүй мэдээллийг хардаг болгох;<br>-Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл, ачааны манифест, лабораторын дүгнэлтийн программын цаг хугацааны тооцооллыг нэмэх;<br>-Боловсруулах жагсаалт мэдээллийг эксел програм руу экспорт хийх;<br>-Экспорт хийхэд ГУБ, ГУАБ нарын хувийн дугаарыг баганаар гаргах;<br>“Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны тайлан-2019”-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 12 ажлаас онцлог дараах ажлууд байна. Үүнд:<br>1.1. Гаалийн хорио цээрийн албаны МХЕГ-т ажиллаж байхдаа хэрэгжүүлдэг байсан ЗГ-ын тогтоол, МХЕГ-ын даргын тушаал, олон улсын гэрээ конвенциуд, бусад орны эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэглэж байгаа тамга, тэмдгийн загварыг судалсан. Гаалийн ерөнхий газрын даргын А/17 дугаар тушаалаар хорио, цээрийн хяналтын тэмдгийн загвар, хэрэглэх аргачлал батлуулж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>“Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хэрэгжүүлэх түр заавар”-ын төслийг боловсруулан, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар батлуулсан.<br>“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-д |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | (АБТ ЭМА) - 3 өдөр 40 минут;<br>4.2. Хилийн боомтын дундаж хугацаа - 1 өдөр 16 цаг 40 минут;<br>4.3. АБТЭМА гүний терминал дундаж хугацаа - 19 цаг 52 минут;<br>5. АГААРЫН ТЭЭВЭР - ИМПОРТ<br>5.1. Хилийн Буянт-Ухаа боомт дахь дундаж хугацаа - 2 өдөр 12 цаг 32 минут;<br>6. АГААРЫН ТЭЭВЭР – ЭКСПОРТ<br>6.1. Хилийн Буянт-Ухаа боомт дахь дундаж хугацаа - 18 цаг 25 минут;<br>6.2.Захиалга дуудлагын экспортын нийт дундаж хугацаа гүний терминал ба хилийн боомтыг оролцуулан 4 өдөр 20 цаг 35 минут;<br>7.ЦХС+ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГА/ЗӨВШӨӨ РӨЛ, ЛИЦЕНЗ<br>7.1.Зөвшөөрөл/лиценз авахад шаардлагатай нийт дундаж хугацаа - 11 цаг 56 минут;<br>7.1.1.Мал эмнэлгийн ерөнхий газар - 2 өдөр 2 цаг 16 минут;<br>7.1.2.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - 14 цаг 54 минут;<br>7.1.3.Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газар -28 минут;<br>7.1.4.Монгол Улсын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим -33 | | өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, гаалийн байгууллагын цахим хаяг customs.gov.mn-д байршуулж, гаалийн газар, хороод болон төрийн зарим байгууллагаас авсан саналыг нэгтгэн төсөлд нэмэлт оруулж байна.<br>Мөн хорио цээрийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа, хорио цээрийн хяналт шалгалт хийхээр CAIS системд оруулсан БТКУС-ийн ангиллын код, хорио цээрийн асуудал хариуцсан гаалийн улсын байцаагчийн ажлын ачааллыг тодорхойлох зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх 6 сарын хугацааг хамруулан дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болон нийтлэг журамд өөрчлөлт оруулахад анхаарах санал боловсруулсан.<br><br>1.2.Шинэчлэгдсэн гаалийн байгууллагын цахим хаяг customs.gov.mn-д гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, гаалийн хяналтын бүс, түр агуулах, гаалийн байгууллагад бүртгүүлсэн оюуны өмчийн эрхэд хамаарах бараа, гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч, хориглосон хязгаарласан бараа, дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараа, зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл, улс хоорондын шуудангийн илгээмжийн талаарх мэдээллийг шинэчлэн бэлтгэж, байршуулсан.<br><br>1.3.АХБ-аас хэрэгжүүлж байгаа “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” /МОН-3313/ төслийн хүрээнд “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын систем”-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй уялдуулан хөгжүүлэх программын ажлын даалгаварт экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл урьдчилан авахаар гаалийн байгууллагад ирүүлж байгаа бичиг баримтыг цахимаар авах, igov.mn программыг gaali.mn-д оруулж, иргэн, аж ахуйн нэгжээс шаардах бичиг баримтын тоог цөөрүүлэн, урьдчилан ирүүлсэн бичиг баримтыг цахимаар гаалийн газар, хороодод дамжуулах, импортын мэдэгдэл, экспортын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | минут зарцуулсан байна. | | гэрчилгээг холбогдох газар хороодод цахимаар хүргэх санал боловсруулж өгсөн. Мөн ЗГ-ын 2022 оны 54 дүгээр тэмдэглэлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ТЕГ-ын Бараа бүртгэлийн нэгдсэн системийн Гэрээ бүртгэлийн программтай гаалийн бүрдүүлэлт, лаборатори, ачааны манифестын программыг цахимаар холбож, уул уурхайн бүтээгдэхүүний гэрээний мэдээлэлтэй тулган шалгалт хийхтэй холбогдуулан нийтлэг журамд өөрчлөлт оруулах төсөлд санал өгч ажилласан.<br>**Үнэлгээ: 100 хувь** |
| 12 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх | Албаны эрэлч нохойн тоо, Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоо, Илрүүлсэн зөрчлийн тоо, Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>-Эрэлч нохойн тоо 19, эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч 16 байгаа нь гаалийн хяналт, шалгалтын тасралтгүй үйл ажиллагааг явуулахад хангалтгүй үзүүлэлт юм. Орон тоо хангалтгүй байгаагаас шалтгаалж, 1 нохойнд оногдох ажлын ачаалал нэмэгдэж, үр дүн буурдаг.<br>-Сүүлийн 4 жилийн дундаж үзүүлэлтээр эрэлч нохой ашиглан илрүүлсэн захиргааны зөрчил 74 байгаа бол эрүүгийн шинжтэй зөрчил 4 байна. | 2021 он<br>-Эрэлч нохойн тоог 15-аар нэмэгдүүлнэ.<br>-Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоог 15-аар нэмэгдсэн байна.<br>-Эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж, зөрчил илрүүлэлтийг өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Хөшигийн хөндийд баригдаж байгаа Эрэлч нохойн сургалтын төвийн шинэ барилгын ажилд санал хүргүүлсэн, Эрэлч нохойн сургалтын төвийн шинэ барилгыг хүлээн авсан байна.<br>2022 он<br>-Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 39 эрэлч нохойтой болно.<br>-Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоог 5-аар нэмэгдүүлж, сургана.<br>-Эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж, зөрчил илрүүлэлтийг өмнөх оны | 1. Гаалийн ерөнхий газрын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/152 дугаар тушаалаар гаалийн албанд ашиглах 15 нохойг, 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/206 дугаар тушаалаар 12 нохойг шинээр данс бүртгэлд бүртгэж авсан. Ингэснээр гаалийн албанд 41 эрэлч нохой ажиллаж байна.<br><br>2. 2021 оны 12 дугаар сард гаалийн байгууллагад эрэлч нохой хариуцагчаар ажиллаж байсан 12 албан хаагчийг гаалийн улсын байцаагчийн чиглүүлэх сургалтад хамруулсан. Мөн Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар болон Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газруудад ажиллах эрэлч нохой хариуцсан 2 гаалийн улсын байцаагчийг томилуулсан.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/363, Б355 дугаар тушаалаар эрэлч нохой хариуцсан 2 гаалийн улсын байцаагч 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Б/664, Б/662, Б/660, Б/661, Б/659, Б/658 дугаар тушаалуудаар эрэлч нохой хариуцсан 6 гаалийн улсын байцаагчийг томилуулсан. Ингэснээр гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр 27 гаалийн улсын байцаагч ажиллаж байна.<br><br>3. 2021 онд харьяа гаалийн 14 газар, хороодод 14 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч 12 эрэлч нохой хариуцагч 26 эрэлч нохойн хамтаар ажиллаж, захиргааны шинжтэй 5, эрүүгийн шинжтэй 3 зөрчил илрүүлсэн. Зөрчил буурсан гол шалтгаан нь Ковид-19 цар тахлаас үүдэн хилээр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Хөшигийн хөндийн Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн байна | нэвтрэх зорчигчийн хөдөлгөөн зогссон, зарим боомтууд хаагдаж, эрэлч нoход ажиллах боломж бүрдээгүй байсантай холбоотой.<br>2022 онд эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нар 19 зөрчил илрүүлэн ажилласан. Энэ нь өмнөх оноос 137,5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br><br>4. Эрэлч нохойн сургалтын төвөөс Хөшигийн хөндийд баригдаж байгаа эрэлч нохойн сургалтын төвийн барилгын ажилтай холбоотой шаардлагатай санал, хүсэлтүүдийг №2021/02, №2021/07, №2021/46 дотоод зурвасуудаар Боомтын хөгжлийн газарт хүргүүлсэн. Барилгуудыг хүлээн авч үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтуудыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс, Эрэлч нохойн сургалтын төв, Үйлчилгээ, аж ахуйн албатай хамтран хийж бэлтгэл ажлыг ханган ажилласан. 2021 оны 11 дүгээр сард Инженер, техникийн албанаас шинээр баригдаж байгаа эрэлч нохойн сургалтын төвийн барилга байгууламжуудын ажил түр хугацаанд зогсож байгаа талаар мэдэгдсэн.<br>2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Хөшигийн хөндийд баригдаж байгаа хилийн хяналтын байгууллагууд болон Эрэлч нохойн сургалтын төвийн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулахаар Төв аймгийн Засаг даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг болон Гаалийн ерөнхий газрын ажлын хэсэг гүйцэтгэгч тал болох Хилийн 0119-р ангийн инженер, дарга удирдлагуудтай уулзаж, хурал хийсэн. Хурлын шийдвэрээр хүлээлцэх хугацааг 1 сараар сунгаж, хийж гүйцэтгэх ажлуудын жагсаалтуудыг хүргүүлсэн. 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр барилга хүлээлцэх Комиссын хурлыг дахин зохион байгуулсан. Хурлын шийдвэрээр барилгуудыг хүлээж авч, зарим нэг жижиг ажлуудыг дуусгах даалгаврыг гүйцэтгэгч талд өгсөн.<br>**Үнэлгээ: 100 хувь** |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих; | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | ЗОРИЛТ 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх, | Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлэх | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар | 2020 он<br>Жил бүрийн төсвийн орлогын төлөвлөгөө ойролцоогоор 20 орчим хувиар өсдөг. Сүүлийн 4 жил төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлсэн.<br>Гаалийн байгууллага нь улсын төсөвт 2020 оны жилийн эцсийн байдлаар 3024.6 тэрбум төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэйгөөс урьдчилсан байдлаар 2891.8 тэрбум төгрөг оруулж, 95.6 хувийн гүйцэтгэлтэй байна. | 2021 он<br>-Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.<br>Гүйцэтгэл 100 хувьтай байна.<br>2022 он<br>-Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна.<br>Гүйцэтгэл 100 хувьтай байна. | 1. 2021 онд:<br>Гаалийн байгууллага нь улсын төсөвт 2021 онд 3560.2 тэрбум төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэйгөөс 3509.1 тэрбум төгрөг оруулж, гүйцэтгэл нь 98.6 хувийн гүйцэтгэл буюу 51.09 тэрбум төгрөгөөр тасарсан. Үүнд<br>1.Хураамжийн орлого 20.0 тэрбум төгрөгөөр, Цар тахлын халдвар дотоодод нэмэгдэж байгаатай холбогдуулан БНХАУ-ын талаас нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоог бууруулж байгаагийн улмаас нүүрсний экспорт оны төгсгөлд төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй буюу 2021 онд 15.7 сая тонн экспортолжээ. Өнгөрсөн оны мөн үеэс 82.0 хувиар буурсан.<br>2.Өөрийн орлого 15.9 тэрбум төгрөгөөр, Тус орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлсэн шалтгаан нь Засгийн газрын 2019 оноос эхлүүлэн хэрэгжүүлж буй хилийн боомтууд дээр эрдэс бүтээгдэхүүн, газрын тос, автобензин, дизель түлшний төрөлжсөн, орчин үеийн лабораториудыг тус оноос үе шаттай байгуулан, лабораторийн техник тоног төхөөрөмж, хүчин чадлыг шинэчлэх “Гаалийн шинэчлэл” ажлын хүрээнд хэмээн тайлбарлаж байна.Гэвч бодит байдал дээр тус төсөл хэрэгжиж эхэлснээр, тоног төхөөрөмж, хүчин чадлыг шинэчилснээр зөвхөн лабораторийн шинжилгээний хураамжийн орлогыг бодит дүнгээр нэмэгдүүлнэ.<br>Түүнчлэн, “Ковид-19” вирусын тархалтыг сааруулах зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр, Улсын онцгой комиссын шийдвэрийг тус тус үндэслэн гарсан дараах хууль эрх зүйн актаас хамаарч гаалийн байгууллагын өөрийн орлого буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:<br> Бүрдүүлэлтийн дараах шалгалтын актын төлбөр 2021 онд 1,5 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Монгол Улсын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар 2021 онд бүрдүүлэлтийн дараах шалгалт хийхийг зогсоосон тул тус төрлийн орлого 2019 онтой харьцуулахад 3.29 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 4 дүгээр заалт “БНХАУ-тай хиллэх хилийн авто замын боомтоор тээврийн хэрэгслээр болон явганаар нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнд түр хугацаагаар хязгаарлалт хийх” , УОК-ын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Хилийн зарим боомтыг түр хаасантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 1 дүгээр тогтоолын дагуу дагуу зорчигчийн хөдөлгөөн хязгаарласантай холбоотойгоор зорчигчийн бүрдүүлэлтийн барааны татвар /Маягт№2-оор/ 2021 онд 0.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.<br>3.Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 19.5 тэрбум төгрөгөөр, Нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаатай холбогдуулан нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн дизелийн түлшний хэрэглээ төлөвлөснөөс буурч байгаа учир шалтгаанаар 1.56 сая тонн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буурсан нь дизель түлшний онцгой албан татвар, дизель түлшний албан татварын орлогын дүн төлөвлөснөөс 19.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна.<br>2021 онд 14.7 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн татварын авлагыг барагдуулан ажилласан.<br>2022 онд:<br>"Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 2022 онд тодотголоор 4.1 их наяд төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Гаалийн байгууллага нь 4669.0 төгрөг төвлөрүүлж, 113.9 хувийн гүйцэтгэлтэйгээр, 570.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн үзүүлэлтэй байна.<br>1. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуулийг үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарийг батлах” А/23 дугаар тушаал, "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийг үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 05-ний өдрийн “Улсын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарийг батлах” А/129 дүгээр тушаалыг хавсралтын хамтаар тус тус харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>2. Шинэ үеийн гаалийн алба үүсэж, хөгжсөний 110 жилийн ойг тохиолдуулан харьяа гаалийн газар, хороодын дунд хяналт шалгалтын дэвшилтэт технологи ашиглан улсын төсөвт орлогыг үр дүнтэй төвлөрүүлэх, татвараас зайлсхийх зөрчлийг тухай бүрт илрүүлэх, гаалийн болон бусад татварын чөлөөлөлтийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах, татварын өр авлагыг барагдуулах чиглэлээр Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/171 албан бичгээр улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр “Аян зохион байгуулах тухай” 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн хооронд Татварын орлогын газар, Гаалийн хяналт, шалгалтын газар, Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар хамтран зохион байгуулсан.<br>3.Мөн өр, авлагыг барагдуулахаар Татварын орлогын газар Хуулийн хэлтэстэй хамтарч ажиллах төлөвлөгөө /2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр/ гаргасан ба уг ажлын хүрээнд хойшлуулсан татварын өртэй ТОСК-тай 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци-тай 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр тус тус уулзалт зохион байгуулсан. ТОСК-аас БХЯ руу уг татварын өрийг шилжүүлэх саналтай байгаагаа илэрхийлсэн бөгөөд энэ асуудлаар ТОСК, БХЯ, гаалийн байгууллага 3 талт уулзалт зохион байгуулах шийдвэрт хүрсэн боловч тодорхой шалтгаануудын улмаас уулзалт зохион байгуулагдаагүй. Гаалийн ерөнхий газраас 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 01/2/3113 албан бичгийг БХЯ-д хүргүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1в/4313 албан бичгээр БХЯ хариу ирүүлсэн. Улаанбаатар хотын хөгжлийн корпорацын зүгээс Нийслэлийн засаг дарга болон НИТХ-д үүсээд байгаа өр, авлагыг шийдвэрлүүлэх талаар нэн даруй танилцуулж, үүсээд байгаа өр, авлагыг барагдуулах талаар албан бичгийг ойрын хугацаанд Нийслэлийн засаг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | | | | | | даргад хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Улаанбаатар хотын хөгжлийн корпораци-аас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Цахилгаан автобустай холбоотой асуудлыг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг гүйцэтгэх захирал Н.Баярчимэгт даалгасан байна.<br>Монцемент билдинг материалс ХХК-ийн Засгийн газрын 2014 оны 317, 2015 оны 191, 2017 оны 191 дүгээр тогтоолоор 2 жилийн хугацаагаар татвар төлөлтийг нь хойшлуулах шийдвэр гарч үүсээд буй импортын гаалийн албан татвар 20,9 тэрбум төгрөг, Гаалийн тухай хуулийн 2941 дүгээр зүйлийн 2941.1-т заасны дагуу татварын хугацаа хожимдуулсны хүү 11,5 тэрбум төгрөгийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг нөхөн төлүүлэх, өрийг барагдуулахаар шүүхэд удаа дараа нэхэмжлэл гарган ажиллаж байна.Монцемент билдинг материалс ХХК-ийн 22.9 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагаас 1.8 тэрбум төгрөгийг төлж, барагдуулсан байна.<br>Татварын орлогын газрын гаалийн улсын ахлах байцаагч Б.Эрдэнэбатаар ахлуулсан бүрэлдэхүүн Улаанбаатар хот дахь гаалийн газарт очиж, тухайн газарт өртэй 6 аж ахуйн нэгжийн 11,2 тэрбум төгрөгийн татварын өр, авлага шийдэгдэхгүй байгаа болон эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар хуралдаж, цаашид ямар арга хэмжээ авч, өр, авлагыг барагдуулах талаар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн.<br>Тайлант хугацаанд 320,7 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулж, хугацаанд нь барагдуулж ажилласан. Тайлант хугацаанд хойшлуулалтын хугацаа хэтэрч өр, авлага үүсгэсэн аж ахуйн нэгж байхгүй. Оны эхэнд төлөгдөөгүй үлдэгдэлтэй байсан М-Ойл групп ХХК-ийн 391,6 сая, Ай Си Ай Си ХХК-ийн 531,8 сая төгрөгийн хойшлогдсон татварын үлдэгдлийг төлүүлж, авлагыг бүрэн барагдуулж ажилласан.<br>Өмнөх онуудад үүссэн татварын хойшлуулалтын авлагуудаас 2,7 тэрбум төгрөгийг төлүүлсэн.<br>**Үнэлгээ: 100 хувь** |
| 14 | ЗОРИЛТ 3: Улсын | Барааны гарал үүсэл, тарифын | Хэрэгжилт, гүйцэтгэлэ | 2020 он Монгол Улсын Япон | 2021 он Ази Номхон далайн | Ази Номхон далайн худалдааны хэлэлцээрийн барааны гарал үүсэл, тарифын хөнгөлөлтийг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.<br>-Гадаад худалдааны статистикийн ухаалаг хайлтын программ нийтийн хүртээл болсон байна.<br>-Гадаад худалдааны нэгдсэн порталд оруулах үйл ажиллагаа жигдрэн, хэрэглэгчид монгол, англи хэл дээр мэдээлэл хүлээн авах боломжтой болно.<br>-Гаалийн байгууллагаас олгож буй Гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Гаалийн баталгаат үйлдвэрийн газрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Гаалийн тусгай бүсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлснээр аж ахуйн нэгжээс гаалийн байгууллагад гаргасан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, олгох явцыг ил тодорхой болгож, хяналтыг сайжруулна.<br>-Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор хийгдсэн программыг туршилтаар нэвтрүүлнэ.<br>- Цахим портал системд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний бүртгэлийг сайжруулж, мэдээллийн | 19) “Үндэсний кодод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2020 оны А/166 дугаар тушаал,<br>20) “Журам батлах тухай” 2021 оны А/118 дугаар тушаал.<br>Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна.”, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхгүй.” гэж тус тус заасан байх тул захиргааны хэм хэмжээний актын дараах төслийг Гаалийн байгууллагын цахим хуудсанд байршуулж санал авч, хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгч түгээсэн. Үүнд:<br>1.ГЕГ-ын даргын 2019 оны А/276 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмуудад өөрчлөлт оруулах төсөл. /санал авах хугацаа 2022.10.03 - 2022.11.03/<br>2.“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын төсөлд санал авах тухай /2022.07.06-2022.08.06/<br>3.Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн газар, хороодоос олгож байгаа "экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдэл олгох журам"-ыг шинэчилж, импортын мэдэгдэл, импортын гэрчилгээг цахимаар олгох журмын төсөлд санал авах хугацаа /2022.12.18/<br>4.Гаалийн-тусгай-бүсийн-горим-хэрэгжүүлэх-журам-/санал авах хугацаа 2022.11.08-2022.12.08<br>5."тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур"-ыг шинэчлэн боловсруулсан төсөл /санал авах хугацаа 2022.11.08-202212.08/<br>6.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны а/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл/санал авах хугацаа 2022.11.28-2022.12.28/<br>7.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны а/223 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-д |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аюулгүй байдлыг хангаж ажиллана. | нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл /санал авах хугацаа 2022.11.28-2022.12.28/<br>8.Гаалийн хяналтын нийтлэг журмын төсөл<br>9.Татваргүй барааны дэлгүүрийн сонгон шалгаруулалт явуулах, зөвшөөрөл олгох журам<br>10.Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, үндэсний кодод оруулах 2022 оны нэмэлт, өөрчлөлт<br>11.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам<br>12.Гаалийн төв лаборатори-мшх журам шинэ төсөл 2021.11.15<br>13. Гаалийн хяналтын бүсийн журам-д оруулах өөрчлөлтийн төсөл<br>14.Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам /2022 оны 4 сарын 1-ээс 5 сарын 1/<br>15.Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт<br>16.“гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам” 2022 оны 10 дугаар сарын 20-оос 11 дүгээр сарын 20<br>17.Гаалийн ерөнхий газрын даргын “заавар батлах тухай” 2016 оны а/82 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар” 2022 оны 11 сарын 01-ээс 12 сарын 01<br>18.Үндэсний кодод оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай 2022.11.14-12.14<br>2. Төрийн байгууллага, АНН, иргэдээс 2021 онд 1139 албан бичиг, 534 өргөдөл ирсэн бол 2022 онд мэдээлэл лавлагаа хүссэн албан бичиг 558-р буюу 2 дахин буурч 581 , өргөдөл 517-р буюу 31 дахин буурч 17-өргөдөл ирсэн байна. Буурсан шалтгаан нь Гаалийн цахим лавлагаа Е-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрснээр цахим лавлагааний эрх нээлгэх албан бичиг өргөдөл ирэхгүй болсонтой холбоотой юм.<br>3. НҮБ-аас “Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг шинээр дахин гаргаагүй тул тус аргачлалд өөрчлөлт оруулаагүй.<br>4-5. Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | порталын засвар үйлчилгээний хугацаа дуусснтай холбоотойгоор засвар үйлчилгээ, вэбийг байршуулсан сервер (host) – ийг МУ-д авах, вэбийн эх кодыг хүлээж авах шаардлагын талаар болон бусад агентлагуудаас гадаад худалдаатай холбоотой хууль, журам нэмэгдэх өөрчлөгдөхөд портал руу оруулах тухай журам боловсруулах шаардлагатай байгаа талаарх албан бичгийг ГХЯ-д хүргүүлсэн. Гаалийн байгууллагын 2022 онд өөрчлөлт орсон эсвэл шинээр бий болсон гадаад худалдаатай холбоотой хууль эрхзүйн баримт бичгийн мэдээллийг гаргаж өгөх тухай А4/16 тоот дотоод зурвас явуулж, өөрчлөлт орсон 1 хууль, 1 журам, 2 тогтоолын мэдээллийг гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн порталд оруулсан. Tableau серверт ГЗТХБГ-н хүсэлтийн дагуу зөрчлийн мэдээ тайлан гаргахад шаардлагатай өгөгдлийн мартыг (data mart) өгөгдлийн сангаас бэлтгэж өгч, зөрчлийн мэдээ тайлан гаргах боломжийг бий болгосон. Гаалийн цахим үйлчилгээний www.gaali.mn системд Гадаад худалдааны статистикийн хайлтын программыг хайсан хайлтын дагуу эксель программ руу татах хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.<br>6. МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэл болон төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилготой “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд гаалийн байгууллагаас ГТСМТТ УҮГ-тай хамтран Гаалийн тухай хууль тогтоомжийн дагуу ГЕГ-аас олгож байгаа зөвшөөрлийг цахим болгосон. Гаалийн тухай хууль тогтоомжийн дагуу гаалийн баталгаат бүс, тусгай бүс, гаалийн хяналтын бүс, түр агуулах ажиллуулах болон тээвэрлэгч байгууллагад олгох гаалийн итгэмжлэл авах хүсэлтэй хуулийн этгээд гаалийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд ГЕГ-т хүсэлт гарган, зөвшөөрөл авах боломж нээлттэй байдаг. Дээр дурдсан зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч хянаж, шийдвэрлэснээр ААН-д цаг хугацаа орон зайнаас хамаарахгүйгээр зөвшөөрлийн хүсэлтээ цахимаар илгээж, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг өөрөө хянах боломж бүрдсэн. 2022.12.30-ны өдрийн байдлаар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимаар:<br>-гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх 2 хүсэлт, хугацаа сунгуулах 1 хүсэлт;<br>-татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа сунгуулах 11 хүсэлт;<br>-тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авах 15 хүсэлт, хугацаа сунгуулах 8 хүсэлт;<br>-гаалийн хяналтын бүс тогтоолгох 9 хүсэлт, хугацаа сунгуулах 4 буюу нийт 50 хүсэлтийг хүлээн авч, 16 хүсэлтийг шийдвэрлэн, 34 хүсэлтийг хянаж байна.<br>Гаалийн удирдах төв байгууллагаас олгодог гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар, гаалийн баталгаат үйлдвэрийн газар, гаалийн баталгаат барилгын талбайн газар, гаалийн тусгай бүсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг өнөөдрийн байдлаар цахимаар ирүүлээгүй байна.<br>7. Гаалийн шинэчлэлийн хүрээнд ТБД-ийн программыг CAIS-д холбох бэлтгэл ажлыг хангаж, программын бодлогын даалгаврыг боловсруулж, ГЕГ-ын МТТ, Аствишн ХХК-д хүргүүлэн хөгжүүлэлтийг хийлгэсэн. Программыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ТБД-ийн зөвшөөрөл эзэмшигч нарт мэдээлэл өгөх, програмын нөхцөл шаардлагуудыг танилцуулах чиглэлийг СЭГГ-т 02-1/2526, УБГГ, ЧХОУНБГГ-т 02-1/2831 дугаартай албан бичгүүдээр тус тус хүргүүлсэн. ТБД-ийн программыг нэвтрүүлснээр дараах мэдээллийг тухай бүр CAIS-д илгээх боломжтой болно:<br>-ТБД-ийн горимоор хийгдсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээ:<br>- горимд байршуулсан бараа;<br>- дэлгүүрийн горимоос бусад горимын кодоор бүрдүүлэлт хийсэн бараа;<br>-борлуулсан барааны буцаалт;<br>-бусад;<br>-дэлгүүрийн борлуулалтын мэдээ;<br>-дэлгүүрүүд горимын дагуу холбогдох баримт бичгийг үндэслэн үйлчилснийг нотлох мэдээ.<br>Мөн ГЕГ-ын 2019 оны А/223 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журам"-ын 2.3.1-д заасан барааг зөвшөөрсөн хэмжээнээс илүү тоо хэмжээгээр борлуулж, кассын бичилт хийх боломжгүй тохиргоо хийгдсэн. Дээрх программыг Замын-үүд чөлөөт бүсэд дэлгүүрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5 дэлгүүрт туршилтын журмаар 2022.06.15-ны өдрөөс нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2023 онд УБГГ-ын хяналтад үйл ажиллагаа эрхэлж байгаа 5 дэлгүүрт нэвтрүүлнэ.<br>8. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим системд шилжүүлэх программын хөгжүүлэлт 2021 оны 9-р сард хийгдэж дууссан. Сангийн Сайдын 2021 оны 122 дугаар тушаалаар "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагаас олгох тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх журам" батлагдсан. Түүнчлэн тусгай зөвшөөрлийн цахим системийн нэгдсэн гарын авлага болон гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргахад цахим системийг ашиглах зааврыг гаргасан. 2022 онд 36 аж ахуйн нэгжийн гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт, 2 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл эрхлэх хүсэлтийг тус тус https://license.mof.gov.mn/ цахим системээр хүлээн авч, Сангийн сайдын 2022 оны 110, 126, 252 дугаар тушаалуудаар шийдвэрлүүлсэн болно. Тусгай зөвшөөрлийн цахим системд https://license.mof.gov.mn/ гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 54 аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл /аж ахуйн нэгжийн нэр регистрийн дугаар, лавлагаа тодорхойлолтын маягт, зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, хаяг байршил гэх мэт/ ил тод нээлттэйгээр байршуулсан. Гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийн https://cims.gaali.mn сайтын зөвшөөрөл бүртгэл цонхонд 60 гаалийн зуучлагч байгууллага болон тэдгээрийн 283 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний мэдээллийг шинэчлэн оруулсан. Дээрх системд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нар тоон гарын үсгээр нэвтэрч ашиглах зохицуулалттай тул тоон гарын үсгийн токен төхөөрөмжийн талаарх мэдээллийг гаалийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зуучлагч аж ахуйн нэгжүүдэд хүргэж ажилласан. Гаалийн мэдээллийн удирдлагын системд https://cims.gaali.mn гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн хэсэгт түүхчилсэн сан программын хөгжүүлэлт хийгдсэн. Түүхчилсэн сангийн мэдээлэлд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний системд ажиллах эрх олгох, түдгэлзэх, сэргээх, хүчингүй болгох, системд нэвтрэх эрхийг гаалийн газар, хороодтой холбох, шилжилт хөдөлгөөн болон хууль сахилтын түвшинг бүртгэх боломжтой болгосон. Зөвшөөрлийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль батлагдсан болон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалаар “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6082 дугаарт бүртгүүлсэн. Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар газар хороодод 02-2/3769 тоот албан бичгээр хүргүүлж, cerp-д байршуулсан болно.<br>**Үнэлгээ 90 хувь** |
| 26 | ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах,. | Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 2020 он<br>Цахим нэг цонхны систем байхгүй. 2019 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй RIBS төслийн хүрээнд Цахим нэг цонхны суурийг бэлтгэх ажил хийгдэхээр болсон.<br>2020 онд Цахим нэг цонхны бизнес процессын судалгаа хийх зөвлөх PWC олон улсын аудитын компани шалгарч, 2020 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн. | 2021 он<br>-RIBS төслийн хүрээнд PWC олон улсын аудитын компанитай “Цахим нэг цонхны систем”-ийн бизнес процессын судалгаа хийхэд хамтран ажиллаж, санал хүргүүлсэн байна.<br>-Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан “Цахим нэг цонхны багц” бичиг баримтыг судалж, хэрэгжүүлэх боломжтой санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх талаар санал боловсруулан ажилласан байна.<br>2022 он<br>-Гаалийн мэдээллийн технологийн системийн | Нэг цонхны системийг хэрэгжүүлэх хүрээнд АХБ-аас 2021 онд зохион байгуулсан "Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ" хийх ажлын хэсэгт орж ажиллан, гадаад худалдааны нэг цонхны системийг хэрэгжүүлэхэд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгч, ирээдүйд бий болох "Гадаад худалдааны нэг цонхны систем"-ийн загварыг гаргахад саналаа тусган ажилласан. ДГБ-ын "Нэг цонхны компендиум"-ийн I, II ботийг 2022 онд орчуулан, хэвлэж цахим болон цаасан хэлбэрээр хамтран ажилладаг байгууллага, харьяа гаалийн газар, хороодод түгээсэн. Цахим нэг цонхны менежментийн зөвлөх үйлчилгээний төслийн зөвлөх компани PWC олон улсын аудитын компанитай "Цахим нэг цонхны систем"-ийн бизнес процессын судалгаа хийхэд хамтран ажилласан. Тус төслөөс “Өнөөгийн байдлын Тайлан”, “Зорилтот байдлын тайлан”, “Удирдлагын өөрчлөлтийн тайлан”, “Техникийн шаардлагын тайлан”, “Хууль, эрх зүйн тайлан” |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслийн хүрээнд хийгдэх “Цахим нэг цонхны систем”-тэй уялдуулах туршилтын ажлыг эхлүүлсэн байна. | болон “Гадаад худалдааны цахим нэг цонхны нэгдсэн тайлан”-г Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр мон/3387/151 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс "Цахим нэг цонхны систем"-ыг бий болгоход удирдаж явах болон цаашид дараа авч явах агентлагыг сонгох ажил хүлээгдэж байгаа. Цахим нэг цонх бий болоогүй байна.<br>**Үнэлгээ 70 хувь** |
| 27 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн (RIBS) хүрээнд 2019 онд тоон гарын үсэг тээгч 1800 токен төхөөрөмж худалдан авсан.<br>2020 онд Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгжийн дарга, гаалийн улсын ахлах байцаагч нарт Үндэсний дата төвөөс тоон гарын үсгийн сертификатыг худалдаж авсан. | 2021 он<br>-Системийн хэмжээнд удирдлагууд болон хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгосон байна.<br>-Тоон газрын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүдэд ашигладаг болно.<br>2022 он<br>Системийн хэмжээнд албан хаагч нарт олгосон, гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (RIBS)-ийн хүрээнд хийгдэж буй Гаалийн худалдааны үйлчилгээ эрхлэгчдийн систем (CEPS), Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (CAIS)-дэд тоон гарын үсгээр нэвтрэх хэсгийг боловсруулж, туршилт хийн, тоон гарын үсгээр нэвтрэх орчин хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Мөн шинээр хөгжүүлж буй Гаалийн үйлчилгээний цахим портал болох WWW.GAALI.MN системд иргэн, аж ахуйн нэгж байгууллага тоон гарын үсэг нэвтрэх хэсгийг боловсруулж, туршилт хийн, тоон гарын үсгээр нэвтрэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.<br>2021 оны Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхтэй холбогдуулан Үндэсний дата төвтэй 2020 онд байгуулсан гэрээг шинэчлэх шаардлага гарч, гэрээг дахин шинэчлэхээр хүргүүлсэн бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 26-ны өдөр “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгоход хамтран ажиллах гэрээ” байгуулсан.<br>● Цахим албан хэрэг хөтлөлтийн E-DOC системийг нэвтрүүлж, тоон гарын үсэг ашиглан баримт бичгийг баталгаажуулах, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагад тоон гарын үсгээр баталгаажсан албан бичиг илгээх болон хүлээн авах боломжийг бүрдүүлсэн.<br>● Цахим гарын үсэг авсан эрх бүхий албан тушаалтнууд CAIS системд цахим гарын үсгээр нэвтрэх боломжийг бүрдүүлж, бүртгэлийг хийсэн.<br>Гаалийн цахим үйлчилгээний систем, гаалийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зуучлагч тээвэр зуучийн CEPS системүүдэд гадаад худалдаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүд 100% цахим гарын үсгээр нэвтэрч байна.<br>Гаалийн төв лабораторийн дүгнэлтийн тоон гарын үсгээр баталгаажуулалт хийх хөгжүүлэлтийг хийж байна.<br>Дотоод зурвасыг цаасгүй болгох, тоон гарын үсгээр баталгаажуулалт хийх хөгжүүлэлт дууссан, тэст хийж бэлэн болгосон.<br>Гаалийн ерөнхий газрын дарга нарын нийт 22 тоон гарын үсгийн сунгалтыг Үндэсний дата төвд хийлгэсэн. Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн төвийн 11 гаалийн улсын байцаагч нарын тоон гарын үсгийн сунгалтыг Үндэсний дата төвд хийлгэсэн. Гаалийн ерөнхий газрын Гаалийн төв лабораторийн 23 гаалийн улсын байцаагч нарын тоон гарын үсгийн материалыг бүрдүүлж, Үндэсний дата төвд шинээр тоон гарын үсгийн олголт хийлгэсэн.<br>**Үнэлгээ 30 хувь** |
| 28 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Гаалийн мэдээллийн системүүдийг боловсронгуй болгож, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг бий болгох | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 2020 он<br>2019 онд “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн (RIBS) хүрээнд гаалийн мэдээллийн системийг сайжруулах 15 ажлыг гүйцэтгэх ажлын зөвлөх компаниар Аствишн ХХК шалгарсан.<br>2020 онд хийгдэх 15 ажлын судалгаа, системийн шинжилгээний ажил 70 хувь, программ хөгжүүлэлтийн ажил 40 хувьтай явагдаж байна.<br>Гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Мэдээлэл алдагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна. | 2021 он<br>-Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд хийгдэх 15 ажлыг бүрэн хийж дуусгасан байна.<br>-Сервер тоног төхөөрөмжийг шинээр авч суурилуулан, гаалийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.<br>- Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг сайжруулна.<br>- Гаалийн мэдээллийн системүүд рүү албан хаагчид тоон гарын үсэг болон тээгч төхөөрөмжийг /токен/ ашиглан нэвтрэх боломжийг бүрдүүлснээр мэдээллийн систем рүү хандах эрхээ бусдад дамжуулах боломжгүй | "1. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд хийгдэх 15н ажил бүрэн дуусаж, зөвлөх компанитай хамтран ажиллаж программуудын туршилт хийн, шат дараатайгаар үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br>Программын модулийн нэр Нэвтрүүлсэн огноо<br>Импорт, экспортын гаалийн мэдүүлэг 2022-02-23<br>Эскпортын гаалийн мэдүүлэг (Эрдэс бүтээгдэхүүн) 2022-06-07<br>Тээврийн программ (Агаар) 2022-02-23<br>Тээврийн программ (Төмөр зам) 2022-08-28<br>Тээврийн программ (Авто зам) 2022-11-07<br>Импорт, транзит манифест 2022-08-29<br>Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест 2022-11-07<br>Хувь хүний барааны гаалийн мэдүүлэг 2022-08-15<br>ЭЗИО-н программ 2021.11<br>Төслийн зөвлөх компаниас гэрээг дүгнэж, баталгаат засварын хугацаанд хийх ажлын жагсаалтыг гаргаж, хугацааны хамт ирүүлсэн байна.<br>**Үнэлгээ 100 хувь**<br><br>2. Сервер тоног төхөөрөмжийн шинэчлэлийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан хаагчдыг ажлын компьютероос албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, Гаалийн ерөнхий газрын албан хаагчдын компьютеруудыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбосон. | болж, мэдээллийн аюулгүй байдал хангагдсан байна.<br>-Албан хаагчдыг ажлын компьютераас албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын албан хаагчдын компьютеруудыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбоно.<br>Ингэснээр ажилтан, албан хаагчид мэдээллийг ямар зорилгоор системээс авч байгаад хяналт тавих боломж бүрдэнэ.<br><br>2022 он<br>- Гаалийн мэдээллийн системийг Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд хийгдэх цахим нэг цонхны суурь системтэй уялдуулсан байна.<br>- Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, ажил үүргийн хуваарийн дагуу албан хаагчид мэдээллийн систем рүү хандаж, тодорхой эрхийн хязгаарлалтуудаар ашиглах боломжийг бүрдүүлэн бусад ажилтан, албан хаагчийн нэвтрэх эрхийг хязгаарлан мэдээллийн аюулгүй байдлыг хангана.<br>- Гаалийн байгууллагын | хүрээнд тоног төхөөрөмжийн 2-р хэсгийг нийлүүлэх гэрээний дагуу Summit компанийн хариуцсан инженерүүд МТТ-ийн хариуцсан инженерүүд хамтран, тоног төхөөрөмж, дагалдах техник хэрэгсэл, программ хангамжийн лицензийг акт үйлдэн хүлээж авсан. Тоног төхөөрөмжийг гаалийн мэдээллийн нэгдсэн дата төвд байршуулсан ба сүлжээний тоног төхөөрөмжүүдийн тохиргоог хийсэн. RIBS төслийн хүрээнд шинээр нэвтэрч буй системүүдэд тус төхөөрөмжүүдийг тест хийх нөхцөл бололцоогоор хангаад байна. Шуурхай удирдлагын төвийн 60 дэлгэц болон сервер, компьютер, сүлжээний тоног төхөөрөмж, 9-р давхрын хурлын өрөөний дэлгэцүүдийн түвшинг доошлуулж, хурлын өрөөний хөгжим техникийн дуугаралтын тохиргоог хийж, техник хэрэгсэлд тогтмол тохиргоог хийж, аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд сервер, сүлжээний тоног төхөөрөмж суурилуулж, ажиллагаанд оруулсан. мөн дата төвийн хэвийн ажиллагааг хангах үүднээс шинээр 120kB UPS суурилуулж, ажиллагаанд оруулсан. шинээр суурилуулсан сервер тоног төхөөрөмж дээр gaali.mn, ceps.gaali.mn системүүдийг суурилуулж ажиллагаанд оруулж, хэрэглэгчдэд илүү хурдан найдвартай ажиллагаагаар хангаж ажилласан. • КАИС, СЕПС системд ашиглагдаж буй өгөгдлийн сан /Oracle11g/-гийн хувилбарыг шинэ өгөгдлийн сангийн серверт шинэчлэн / Oracle19c / оруулж хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.<br>• КАИС, СЕПС системийн өгөгдлийн сан шинэчлэгдсэнтэй холбоотойгоор ашиглагдаж буй серверийн холболт болон бусад серверийн холболтыг шинэ өгөгдлийн сантай холбож хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.<br>• Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд нийлүүлэгдсэн өгөгдлийн сангийн шинэ серверт ЗДАС системд ашиглагдаж буй өгөгдлийн санг /Oracle11g/ шилжүүлэн суурилуулсан / Oracle19c /. Үүнтэй холбоотойгоор системийн ажиллаж буй серверт холбогдох тохируулгыг хийж 2022 оны 04 сарын 21-нд хэвийн найдвартай үйл ажиллагаанд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн аюулгүй байдлын талаар албан хаагчдад сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн байна.<br>- Албан хаагчдыг ажлын компьютераас албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын албан хаагчдын компьютеруудыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбоно. Ингэснээр ажилтан, албан хаагчид мэдээллийг ямар зорилгоор системээс авч байгаад хяналт тавих боломж бүрдэнэ. | оруулсан.<br>**Үнэлгээ 100 хувь**<br>3. Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 12-р сарын 23-ны өдрийн А/255 тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журам”-г хэрэгжилтийг хангах үүднээс гаалийн байгууллагын системд байгаа албан хаагчдад журмын хэрэгжилтийг хангах үүднээс тус журамтай танилцуулж ажилласан. Албан хаагчдыг ажлын компьютероос албан мэдээллийг хувийг зорилгоор ашиглах байгаа талаар хянах боломжийг бүрдүүлэх үүднээс төхөөрөмжийн тохиргоо болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Гаалийн байгууллагын дата төвийн мэдээллийн аюулгүй байдал болон сүлжээний аюулгүй байдлыг хангаж, ажиллаж байна. Өдөрт 800-900 халдлага байх магадлалтай тохиолдлуудыг гадаад, дотоод галт хана “Firewall” илрүүлж аюулгүй байдлыг хангасан. Тус хугацаанд 6 эрсдэлтэй тохиолдлыг илүүлж, тухай бүрд нь устгах болон тухай хаягуудыг хаах арга хэмжээг авч аюулгүй байдлыг хангаж ажилласан. Газар хороодод ашиглагдаж байгаа компьютер техник хэрэгслүүдээс хортой код илүүлж, тус компьютерын системүүдийг шинээр суулгах арга хэмжээг авч ажилласан.<br>**Үнэлгээ 100 хувь**<br><br>4. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн хүрээнд гаалийн цахим үйлчилгээний www.gaali.mn систем нэвтэрч гаалийн байгууллагаас үзүүлж буй гаалийн бүрдүүлэлт, төлбөр тооцоо, лавлагаа, тодорхойлолт, хүсэлт шийдвэрлэх, зөвшөөрөл, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл зэрэг иргэнд 13, ААН-дэд 33 үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн шинэчлэл нь Монгол Улс ДХБ-н худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Гадаад худалдааны цахим нэг цонхыг бий болгох ажлын бэлтгэл болж байна. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэгжээс ""Цахим нэг цонхны систем""-ыг бий болгоход удирдаж явах болон цаашид дараа |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч явах агентлагийг сонгох ажил хүлээгдэж байгаа.<br>**Үнэлгээ 90 хувь**<br><br>1. 5. Гаалийн байгууллагад Мэдээллийн аюулгүй байдлын ISO:27001;2013 стандартыг нэвтрүүлэх судалгаа хийх зорилгоор тус стандартыг амжилттай нэвтрүүлсэн Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-тай туршлага солилцох уулзалт хийсэн. Мэдээллийн аюулгүй байдлын ISO:27001;2013 стандартын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ""Менежмент ба ур чадварын хүрээлэн""-гээс сургалт авсан. Төвийн дарга Б.Ганзориг Мэдээллийн цагаар “Мэдээлийн аюулгүй байдлын ISO:27001;2013 стандарт”-ын талаар мэдээлэл хийсэн. Сургалтын материалыг СЭРП-н файлын санд байршуулсан. Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 12-р сарын 23-ны өдрийн А/255 тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журам”-г хэрэгжилтийг хангах үүднээс гаалийн байгууллагын системд байгаа албан хаагчдад журмын хэрэгжилтийг хангах үүднээс тус журамтай танилцуулж ажилласан. Албан хаагчдыг ажлын компьютероос албан мэдээллийг хувийг зорилгоор ашиглах байгаа талаар хянах боломжийг бүрдүүлэх үүднээс төхөөрөмжийн тохиргоо болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Гаалийн байгууллагын дата төвийн мэдээллийн аюулгүй байдал болон сүлжээний аюулгүй байдлыг хангаж, ажиллаж байна. Өдөрт 800-900 халдлага байх магадлалтай тохиолдлуудыг гадаад, дотоод галт хана “Firewall” илрүүлж аюулгүй байдлыг хангасан. Тус хугацаанд 6 эрсдэлтэй тохиолдлыг илүүлж, тухай бүрд нь устгах болон тухай хаягуудыг хаах арга хэмжээг авч аюулгүй байдлыг хангаж ажилласан. Газар хороодод ашиглагдаж байгаа компьютер техник хэрэгслүүдээс хортой код илүүлж, тус компьютерын системүүдийг шинээр суулгах арга хэмжээг авч ажилласан.<br>**Үнэлгээ 50 хувь**<br><br>**Дундаж 88 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах; | | | | | | |
| 29 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Гаалийн байгууллагын хууль тогтоомж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх | Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар | 2020 он<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 234 мэдээллийг олон нийтэд түгээсэн. Үүнд:<br>-52 мэдээллийг www.customs.gov.mn сайтад,<br>-Гаалийн ерөнхий газрын www.facebook.com-д 132 мэдээлэл,<br>-156 мэдээллийг телевизээр,<br>-135 мэдээллийг цахим мэдээллийн хэрэгсэлд,<br>-25 мэдээллийг сонинд өгсөн байна.<br>Олон нийтэд хүргэх гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл 2020 онд өмнөх оноос 46%-аар өссөн. | 2021 он<br>-Гаалийн байгууллагын олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн студи байгуулах боломжийг судалж, веб сайтыг шинэчлэх санхүүжилтийг төсөвт тусгуулна.<br>-Олон нийтэд хүргэх гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн тоог өмнөх оныхоос 5-аас доошгүй хувиар өсгөсөн байна.<br><br>2022 он<br>Гаалийн байгууллагын олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн студи байгуулж, веб сайтаа шинэчилснээр олон нийтэд хүргэх мэдээллийн тоог өмнөх оныхоос 5-аас доошгүй хувиар өсгөсөн байна. | 1. Гаалийн ерөнхий газрын Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төв Мэдээллийн технологийн төв хамтран цахим хуудсаа шинэчлэх асуудлаар Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас санал авч, тодорхой шийдэл гарган сүүлийн үеийн чиг хандлага бүхий цахим хуудасны эх загвар /Wordpress/-ыг ашиглан дизайн, холбогдох бусад бүтцийг нь өөрчилсөн.<br>2021 оны 10 дугаар сард шинэ программ, дизайн бүхий гаалийн customs.gov.mn цахим хуудсыг байгууллагынхаа дотоод нөөц боломж, мэдээллийн технологийн програмист, дизайнерыг ашиглан ашиглалтад оруулсан.<br>2. Гаалийн албан ёсны цахим хуудас www.customs.gov.mn-д 63 мэдээ, 165 пост мэдээллийг гаалийн байгууллагын Mongolian customs Facebook пэйж хуудас болон Монголын гааль twitter хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна. Үүнд:<br>- 63 мэдээллийг www.customs.gov.mn сайтад,<br>- Гаалийн ерөнхий газрын www.facebook.com-д 165 мэдээлэл /олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тоонд оруулаагүй/,<br>- 164 мэдээллийг телевизээр,<br>- 138 мэдээллийг цахим мэдээллийн хэрэгсэлд,<br>- 24 мэдээллийг сонинд,<br>- 65 удаа утсаар болон и-мэйлээр гаалийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг өгсөн байна.<br>Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох телевиз, радио, мэдээллийн цахим хуудсанд, сонинд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 454 мэдээ, мэдээллийг бэлтгэж, түгээсэн нь өмнөх 2020 он /234 мэдээлэл/-той харьцуулахад 220 мэдээллээр илүү буюу 94,02 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>3.Гаалийн байгууллагын олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн студи байгуулах, түүнд зориулж фотокамер зэрэг техник хэрэгсэл худалдан авах асуудал Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу санхүүжилт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгохыг хориглосон, тэвчих зардалд тооцогдсон тул хөрөнгө нь шийдвэрлэгдээгүй. Гэхдээ өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан студийн зайлшгүй хэрэгцээг орлохуйц мини тоног төхөөрөмж болох “Лед” гэрэл, энгэрийн утасгүй микрофон, камерын хөл зэргийг гаалийн үйл ажиллагааг олон нийтэд түгээхэд ашиглаж байна. Ингэснээр Facebook, Youtube нийгмийн сошиал сүлжээнд лайв, подкаст, богино хэмжээний шторк хийх боломж бүрдсэн.<br>Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хурлын үеэр уг тоног төхөөрөмжийг ашиглан "Бид гаалийнхан" группт шууд лайв хийж, 100 гаруй хүн үзсэн нь тодорхой үр дүнд хүрсэн явдал боллоо. Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусгавар болоход сүүлийн үеийн тоног төхөөрөмж худалдан авснаар бидний үйл ажиллагаа хэвийн горимд шилжинэ.<br>Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох телевиз, радио, мэдээллийн цахим хуудсанд, сонинд гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 492 мэдээ, мэдээллийг бэлтгэж, түгээсэн нь өмнөх 2021 он /454мэдээлэл/ -той харьцуулахад 38 мэдээллээр илүү буюу 8,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 185 пост мэдээллийг гаалийн байгууллагын албан ёсны сошиал хуудас Mongolian customs Facebook пэйж-д контент болгож оруулсан. Өмнөх оноос Mongolian customs page-д оруулсан контентийн тоо нь 12%-р өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:<br>-67 мэдээллийг www.customs.gov.mn сайтад,<br>-Гаалийн ерөнхий газрын www.facebook.com-д 180 мэдээлэл /олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тоонд оруулаагүй/,<br>-189 мэдээллийг телевизээр,<br>-167 мэдээллийг цахим мэдээллийн хэрэгсэлд,<br>-29 мэдээллийг сонинд өгсөн байна.<br>-40 удаа утсаар болон и-мэйлээр гаалийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг өгсөн байна.<br>**Үнэлгээ 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх; | | | | | | |
| 30 | ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх, | Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар, Зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх нэгдсэн системийг ашиглан илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар, Илрүүлж, шийдвэрлэсэн нийт зөрчилд нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүн, төгрөгөөр | 2020 он<br>Гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэхээр дараах ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>-Шуурхай удирдлагын төвийн байр ашиглалтад орж, 14 харьяа гаалийн газар, хороодод теле камер суурилуулсан.<br>-CAIS системийн зөрчлийн модуль, эрсдэлтэй зорчигчийн мэдээллийн сан болон бэлэн мөнгөний мэдээллийн санг хэвийн ашиглаж байна.<br>-ДГБ-ын “Үндэсний зөрчлийн мэдээлэл солилцох программ”-ийг ашиглах гэрээ байгуулсан.<br>-Өгөгдлийн сан үүсгэх, боловсруулах Oracle, Access зэрэг программыг нэвтрүүлээгүй.<br>-Мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийж, илрүүлсэн зөрчил байхгүй байна.<br>Гаалийн байгууллага нийт 944 зөрчил илрүүлсэн байна. Дээрх зөрчлүүдэд 1 тэрбум 408.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, 1 тэрбум 989.3 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн байна. | 2021 он<br>-CAIS программын “Зөрчил мэдээллийн сан”-ийн хайлтын хэсгийг нэмэгдүүлсэн байна.<br>-Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг CAIS программд хуулийн хугацаанд нь тогтмол оруулсан байна.<br>-Хувь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, “Зөрчилд холбогдсон эсэх лавлагаа”-ны хариуг цахим хэлбэрээр өгдөг болсон байна.<br>-ДГБ-ын “Үндэсний зөрчлийн мэдээлэл солилцох программ”-ыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна.<br>-Эрүүгийн хэргийн тоо, мөн зөрчлийн хэргийн нөхөн төлбөрийн дүн, зөрчлийн тоог суурь түвшингээс тус бүрийг 5-аас дээш хувиар нэмэгдүүлсэн байна.<br>2022 он<br>-Дэлхийн гаалийн байгууллагын зөрчлийн мэдээллийн nCEN системийг бүрэн нэвтрүүлж, CAIS системийн зөрчлийн программтай холбоно.<br>-Мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт | CAIS программын “Зөрчил мэдээллийн сан”-ийн хайлтын хэсгийг нэмэгдүүлсэн бөгөөд CAIS системийн Эрсдэлийн удирдлага-Зөрчил хэсгийн цэсүүдэд Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон 18 хуулийн 58 зүйл, заалтыг CAIS программд нэмэлтээр оруулсан. Зөрчлийн талаарх лавлагааг цахимаар гаргах ажил программын шинэчлэлт 2021 оны 4 дүгээр улирлаас хэрэгжиж эхэлсэн. Цахим лавлагаа гаргах ажил хэрэгжиж эхэлснээс хойш зөрчлийн тодорхойлолт авах тухай албан бичгийн тоо 1-р улиралтай харьцуулахад 68.6%-иар, 2, 3-р улиралтай харьцуулахад 54.3%-иар буурсан бөгөөд энэ нь иргэн, аж ахуй нэгжүүд зөрчлийн лавлагаагаа цахимаар авах ажил амжилттай хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой гэж дүгнэж байна. ДГБ-ын Үндэсний зөрчлийн мэдээлэл солилцох программ буюу nCEN программын ашиглаж эхлэхтэй холбогдуулан техникийн бэлэн байдлыг хангаж, албан хаагчдыг 2021 онд ДГБ-аас зохион байгуулсан цахим сургалтад хамруулсан бол 2022 онд Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)-ын зөрчлийн мэдээллийн nCEN системийг Гаалийн ерөнхий газрын серверт суурилуулж, тухайн программын талаар мэдээлэл олгох зорилго бүхий ДГБ-аас зохион байгуулсан сургалтад Гаалийн ерөнхий газрын болон харьяа газар, хороодын нийт 13 алба хаагчдыг хамруулсан. Мөн тухайн программын сүлжээний ашиглалтын гэрээний A, B, C хавсралтуудыг монгол хэл дээр орчуулуулж, ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын түвшинд тушаалаар тухайн газар, хороодод тус бүр нэг албан тушаалтныг томилуулж, nCEN сургалтын программ хангамж, сүлжээнд нэвтрэх эрх нээж, зөрчлийн мэдээллийг программд бүртгэж оруулах талаар сургалт зохион байгуулсан. Сургалтын платформын мэдээллийн санд: Саатуулсан бараатай холбоотой 251; Сэжигтэй бараатай холбоотой 225; Компанийн 52, Зураг 156 мэдээлэл тус тус бүртгэгдсэн байна. 2022 онд WCO global CEN сүлжээний /WCO RILO AP - 33th NCP Virtiual |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийж, зөрчлийг илрүүлдэг болсон байна.<br>-Эрүүгийн хэргийн тоо, мөн зөрчлийн хэргийн нөхөн төлбөрийн дүн, зөрчлийн тоог суурь түвшингээс тус бүр 5-аас дээш хувиар нэмэгдүүлсэн байна. | Meeting, Seoul, 2022/ цахим хуралд оролцож, Монголын гаалийн “CEN Experience of Mongolian customs” сэдвээр танилцуулга мэдээлэл хийсэн. Мөн 2022 оны /3th REGIONAL MEETING OF nCEN PROGRAMME LEADERS FOR ASIA-PACIFIC/ цахим хуралд оролцсон. 2021 онд гаалийн байгууллагын хэмжээнд 55 зөрчлийн хэрэг бүртгэлт хийгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 10 зөрчлийн хэрэг бүртгэлтээр буюу 22,2 %-иар өссөн, эрүүгийн шинжтэй зөрчлийн тоо 9 байгаа нь өмнөх оны 19 эрүүгийн шинжтэй зөрчлөөс 10 зөрчлөөр буюу 52,6 % буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд явуулсан 55 удаагийн зөрчлийн хэрэг бүртгэлтэд 436,990,639.2 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 262,393,609.5 төгрөгийн торгууль ногдуулж нийт 699,384,249 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн. Энэ нь өмнөх оноос 6,4 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2022 онд ГЗТХБГ, ШХУТ мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийж нийт 45 зөрчил илрүүлж 248.8 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 118.24 сая төгрөгийн торгууль ногдуулж, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон нийлэг хальсан уутыг их хэмжээгээр нэвтрүүлэх гэсэн гэмт хэргийн шинжтэй 2 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчлийн тоогоор 6 дахин, нөхөн төлүүлсэн татварын дүн 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Улс хоорондын шуудан илгээмжийг ашиглан улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх хар тамхи, мансууруулах бодисын гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж, илгээмжид онилгоо хийх, сэжигтэй илгээмжийг шигших аргачлалыг боловсруулан энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр “Шуудангийн онилгооны программ, модуль”-ийг хэрэгжүүлж, тухайн онд илрүүлсэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой нийт 17 эрүүгийн шинжтэй зөрчлийн 9 удаагийн үйлдлийг илрүүлсэн. Тайлант хугацаанд зөрчлийн хэрэг бүртгэлт 35 удаа явуулж 166,081,585.4 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 157,078,590 төгрөгийн торгууль ногдуулж нийт 323,160,175 төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх оноос 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд тайлант хугацаанд нийт эрүүгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжтэй 31 хэрэг шалган шийдвэрлэсэн нь өмнөх оноос 3,4 дахин буюу 244 %-иар нэмэгдсэн үзүүлэлт юм. Зөрчлийн талаарх лавлагааг цахимаар гаргах ажил программын шинэчлэлтэй холбоотойгоор 2021 оны 4 дүгээр улирлаас хэрэгжиж эхэлсэн. Цахим лавлагаа гаргах ажил хэрэгжиж эхэлснээс хойш зөрчлийн тодорхойлолт авах тухай албан бичгийн тоо 1-р улиралтай харьцуулахад 68.6%-иар, 2, 3-р улиралтай харьцуулахад 54.3%-иар буурсан бөгөөд энэ нь иргэн, аж ахуй нэгжүүд зөрчлийн лавлагаагаа цахимаар авах ажил амжилттай хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой гэж дүгнэж байна.<br>**Үнэлгээ 90 хувь** |
| 31 | ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх, | Гаалийн харилцаанд оролцогчдын хууль сахилтын түвшинг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах | Гүйцэтгэл, нэгжээр, Зөрчлийн тоо, хувиар | 2020 он<br>-Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хувь хүн, хуулийн этгээдэд Гаалийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудаар цахим сургалт явуулж, вэб хуудсанд зөвлөгөө, мэдээллийг дүрстэй болон текст хэлбэрээр байршуулж ажиллаж байна.<br>Гаалийн байгууллагын сүүлийн 4 жилийн буюу 2016-2019 оны дундаж үзүүлэлтээс харахад жилд 2011 хэрэг, зөрчил бүртгэгдсэн байна.<br>Үүнээс:<br>Зөрчлийн тухай хуульд заасан нэгжээр тооцогдох торгуультай зөрчил 534 бүртгэгдсэн байна. | 2021 он<br>-Иргэд бараагаа гаалийн байгууллагад өөрөө цахимаар мэдүүлэх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг эхлүүлсэнтэй холбогдуулан Гаалийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудаар цахим ном бэлтгэн цахим хуудсанд байршуулах, онлайн зөвлөгөө, мэдээллийг тухай бүр өгнө.<br>-Зөрчлийн тухай хуульд заасан нэгжээр тооцогдох торгуультай зөрчлийн тоо хэмжээг өмнөх оны мөн үеэс 5 хүртэл хувиар бууруулсан байна.<br>2022 он<br>-Гаалийн байгууллагын илрүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, сэрэмжлүүлэн, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга | Гадаад худалдаанд оролцогч нарт зориулан гаалийн байгууллагад цахимаар өөрөө бараагаа хэрхэн мэдүүлэх, гаалийн үйлчилгээг цахимаар хэрхэн авах талаар онлайн сургалтыг 4 удаа, танхимаар 1 удаа тус тус хийсэн. Нийт 374 гадаад худалдаанд оролцогч сургалтад хамрагдсан. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарыг хамруулсан ГБМ /УБГГ-149, ЧХОУНБГГ-34, ЗҮГГ-57, СэГГ-16, УХШИГГ-40/ viber группээр дамжуулан шинэчлэгдсэн системээр бараа мэдүүлэхэд гарсан хүндрэл, алдааг тухай бүр засаж сайжруулан, зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн бараагаа цахимаар мэдүүлэх явцад гарсан хүндрэл, хэрхэн бөглөх болон гаалийн бүрдүүлэлттэй холбоотой gaali.mn-ий chatbot хэсгээр ирүүлсэн 70 асуултад тухай бүр хариулж, мэдээлэл зөвлөгөө өглөө. Гаалийн байгууллагын хэмжээнд илрүүлж, шийдвэрлэсэн зөрчлийн мэдээллийг Хэвлэл мэдээлэл, сургалт, судалгааны төвөөр дамжуулан гаалийн байгууллагын албан ёсны сошиал хуудас Mongolian customs Facebook пэйж-д тогтмол нийтэлсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар гарын авлага, мөн иргэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж хувийн мэдээллээ хамгаалах бичиг баримтаа хэн нэгэнд дамжуулахгүй байж хориглосон хязгаарласан барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн хохирогч болох аюулаас сэргийлэх видео шторкийг УХШИГГ-тай хамтран бэлтгэж 25 дугаар суваг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санамжийг цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.<br>-Зөрчлийн тухай хуульд заасан нэгжээр тооцогдох торгуультай зөрчлийн тоо хэмжээг өмнөх оны мөн үеэс 5 хүртэл хувиар бууруулсан байна. | телевиз, Монгол HD телевизээр сурталчилсан. Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын албаны дарга Б. Сүхбаатар албаны бусад хүмүүсийн хамт Чингисхаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын карготерминалд хийгдэж байгаа гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, гаалийн байгууллагын илрүүлж шийдвэрлэсэн хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар мэдээлэл хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулсан. Хэвлэлийн хуралд нийт 45 хэвлэл, мэдээллийн хэрэгслийн 70 гаруй сэтгүүлчид оролцсон. Үнэт эдлэл, үнэт металл, гоёл чимэглэлийн салбарын хамгийн анхны нэгдсэн үзэсгэлэн, чуулга уулзалтыг 2022 оны 4 дүгээр сарын 15-аас 17-ны өдрүүдэд зохион байгуулсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 11/1373 тоот албан бичгийн дагуу тус хэлэлцүүлэг, уулзалтад тус албаны дарга Б.Сүхбаатар оролцож үнэт металл, үнэт эдлэл, эртний эдлэлийн импорт, экспорт, түүнд тавигдах шаардлага, татвар, үнэ тариф тогтоож буй аргачлал болон бусад мэдээ мэдээллийг хүргэж, тулгамдаж буй асуудлуудын хүрээнд хариулт өгсөн. Зөрчлийн тухай хуульд заасан нэгжээр тооцогдох торгуультай зөрчлийн тоо хэмжээ 2021 онд 423 зөрчил болж 111 зөрчлөөр буюу өмнөх оноос 20.8%-иар буурсан үзүүлэлттэй бол 2022 онд 678 зөрчил болж 255 зөрчлөөр буюу мөн үеэс 60.3%-иар өссөн үзүүлэлттэй байгаа нь дараах шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:<br>• 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Гаалийн байгууллагад ХМХА нэгдсэнээр ЗШШТХ-ын 1.8 зүйлийн 6.11-д заасан гаалийн улсын байцаагчид харьяалагдах зөрчлийн зүйлчлэл нэмэгдсэн нь нэгжээр тооцогдох зөрчлийн тоо өсөх шалтгаан болсон бөгөөд гаалийн хорио цээрийн албаны гаалийн улсын байцаагч нарын илрүүлсэн зөрчлийн тоо 166 буюу нийт зөрчлийн 24.4 хувийг эзэлж байна.<br>• 2020-2021 онуудад Ковид 19 цар тахлын улмаас улсын хилээр нэвтрэх бараа эргэлт, зорчигч, тээврийн хөдөлгөөн түр болон бүрмөсөн зогссон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалтгаануудаас гаалийн байгууллагаас илрүүлэх зөрчил эрс багассан байсан. Харин 2022 онд цар тахлын нөлөөлөл буурч ОХУ-тай хил залгаа боомтуудын үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан улсын хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчдын тоо нэмэгдсэн нь нэгжээр тооцогдох зөрчлийн тоо өсөх шалтгаан болсон. **Үнэлгээ 100 хувь** |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх; | | | | | | |
| 32 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шударга ёсыг эрхэмлэн ажиллах | ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтын тоо, хувиар, Гаалийн байгууллагын шударга байдлын үнэлгээг өсгөх зорилгоор зохион байгуулах ажлын тоо Гаалийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, хувиар | 2020 он<br>-2020 онд хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих нийт 1057 төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, сэлгэн ажилласан болон шинээр томилогдсон 486 албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ /271 ХАСХОМ, 215 ХАСУМ/-ын баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулсан. Хугацаа хоцроосон болон ХАСХОМ мэдүүлээгүй албан хаагч байхгүй.<br>-Авлигатай тэмцэх газрын “Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ”-ний 2019 оны дүнгээр Гаалийн ерөнхий газар 64.8 оноо үнэлэгдсэн. | 2021 он<br>-Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, 100 хувь баталгаажуулсан байна.<br>-“Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ” дэх Гаалийн байгууллагын үнэлгээг өсгөх зорилгоор Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 70-аас дээш оноогоор дүгнэгдсэн байна.<br>2022 он<br>-Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, 100 хувь баталгаажуулсан байна.<br>-Авлига, ашиг сонирхлын | 1.Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ, ХАСУМ мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээн авч, 100 хувь баталгаажуулсан байна. Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын 2021, 2022 онд хөрөнгө орлогоо шинэчлэн гаргах үүрэгтэй нийт 2516 төрийн жинхэнэ албан хаагч хөрөнгө орлогоо мэдүүлж, 100 хувь баталгааны маягтаа хүлээлгэж өгсөн. Шинээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон болон сэлгэн ажилласан 495, хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон 100 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуульд зааснаар 30 хоногийн хугацаанд хянаж, баталгааны маягтыг хүлээж авсан. Албан тушаалд томилох, сэлгэн ажиллуулахаар 2021-2022 онд нийт 486 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй болно гэсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж шийдвэрлэсэн байна.<br>2.Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, 2021 оны үнэлгээгээр Гаалийн байгууллага 68.2 оноо авсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | байна. 2022 онд “Шударга байдлын үнэлгээ” -г ЭС АЙ СИ ЭЙ ХК төрийн бус байгууллага шалгарсан болохыг Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03/6832 тоот хавсралтад заасан төрийн байгууллагуудын “Судалгааны ажил гүйцэтгүүлэх тухай” албан бичгийн мэдээлэл цуглуулах ажлын нэгдсэн үнэлгээ хараахан гараагүй байна гэсэн тайлбартай байна.<br>Авлигатай тэмцэх газрын захиалгаар “Онч шийдэл” төрийн бус байгууллагаас 2021 оны 4 дүгээр улиралд Замын-Үүд дэх гаалийн газрын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/13628 дугаар албан бичгээр Замын-Үүд дэх гаалийн газарт 6 зөвлөмжийг хүргүүлсэн.<br>-Замын-Үүд дэх гаалийн газарт өгсөн зөвлөмжид дурдагдсан эрсдэлийг бууруулах, арилгах зорилгоор 2022 оны 1 дүгээр сараас эхлэн “Замын-Үүд дэх гаалийн газраас авлигын эсрэг чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг улирал бүр тооцон ажиллаж байна.<br>- Авлигатай тэмцэх газраас 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан уулзалт, ярилцлагаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хараат бус судлаачаар гүйцэтгүүлж байгаа энэ хүрээнд хэрэгжүүлэгч байгууллагуудад хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, ач холбогдол, ололт амжилт, зөвлөмжийн талаарх гаалийн байгууллага өөрийн үнэлгээг хийж, 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/2419 албан бичгээр хүргүүлсэн ба уг тайланд Замын-Үүд дэх гаалийн газрын зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар тусгасан болно.<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:<br>1.Албан хаагчдыг авлига авах, өгөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор постер хийж, Гаалийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудаст байршуулсан. Мөн харьяа гаалийн газар, хороодод дотоод сүлжээгээр мэдэгдсэний дагуу 18 гаалийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар, хороо албан ёсны цахим хуудаст байршуулсан. https://customs.gov.mn/iltod/2014-03-24-06-25-21/2014-05-22-06-05-28<br>2.АТГ-аас цахим шуудангаар ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад хамрагдаж байгаагүй албан хаагчдын судалгааг гаргаж, 11 албан хаагчийн мэдээллийг нэгтгэн тус газарт 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр цахим шуудангаар хүргүүлсэн.<br>3.АТГ-аас ирүүлсэн 19 төрлийн постер, 14 төрлийн видео шторкийг Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт, гаалийн байгууллагын цахим хуудас /www.customs.gov.mn/-д болон Гаалийн ерөнхий газрын 1-р давхрын цахим мэдээллийн дэлгэцэд байршуулсан.<br>4.“Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд бэлтгэсэн “Тангараг” нэртэй богино хэмжээний видео зохиомжийг Гаалийн ерөнхий газрын цахим хуудасны нүүр хэсэгт байршуулж, олон нийтэд хүргэсэн.<br>5.Гаалийн байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу боловсруулж, Гаалийн ерөнхий газрын даргаар 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулан, харьяа гаалийн газар, хороодод албан бичгээр, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад дотоод зурвасаар хүргүүлж, ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>https://customs.gov.mn/iltod/2014-03-24-06-235-21/2014-05-22-06-04-03/2422-2021<br>5.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг АТГ-аас хүлээн авч, Гаалийн ерөнхий газрын 1-р давхрын хүлээлгийн танхимд байршуулсан.<br>6.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцдаг албан тушаалтнуудад зориулсан сургалтад 1, Авлигын эсрэг анхан шатны сургалтад харьяа гаалийн газар, хороодын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11 албан хаагч, Төрийн албаны удирдах албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг давтан сургалтад 1, Яам, агентлагуудын хуулийн асуудал эрхэлсэн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалтад 1, Агентлагуудын харьяа байгууллагын хуулийн асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалтад 3, Авлигын шалтгаан нөхцөл, хор уршиг, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Авлигын гэмт хэргийн талаарх шинэ зохицуулалт, анхаарах асуудал сэдэвт сургалтуудад 152, нийт 169 албан хаагч хамрагдсан.<br>7.Сангийн сайдаас Гаалийн ерөнхий газрын удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын дагуу ‘Транспэрэнси интернэшнл байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах зорилго бүхий ажлын хэсгийн эрчимжүүлсэн арга хэмжээ”-г гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх 3 зорилт, 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд /chimidsuren_ch@mof.gov.mn/ хаягаар долоо хоног бүрийн Пүрэв гарагт хүргүүлж байна.<br>-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 заалт /төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх/-ын дагуу шилэн дансны цахим хуудас /www.shilendans.gov.mn/ байршуулсан.<br>8.Гаалийн байгууллагын зүгээс авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөлд дайчлан ажиллуулах, сэлгэн ажиллуулахаар хууль тогтоомжид заасан хугацаанд хүрсэн, албан ажлын зайлшгүй шаардлагаар төрийн тусгай албан хаагчийг тухайн албаны байгууллага, нэгж хооронд сэлгэн болон шилжүүлэн ажиллуулахад энэ хуулийн 44.1, 44.2 дахь хэсэг хамаарахгүй” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байгаа талаар Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/1062 албан бичгээр, Төрийн албаны зөвлөлийн гишүүн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Б.Идэрчулуунд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01-1/513 албан бичгээр, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 01/1121 албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>9.АТГ нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх үүргийн дагуу 2 жил тутамд “Шударга байдлын үнэлгээ” тайланг гаргадаг. 2019 оны “Шударга байдлын үнэлгээ” тайланд Гаалийн ерөнхий газар 64,8 оноо авсан. Тус тайланд албан хаагчдын үнэлгээ өссөн хэдий ч иргэд болон шинжээчдийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байсан. Сангийн Сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр баталсан “ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ БАЙГУУЛЛАГААС ГАРГАДАГ АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /ИНДЕКС/-ИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГО БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН ЭРЧИМЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ”-г Гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулж удирдлагаар батлуулсан. Өгсөн үүрэг даалгаврын дагуу 2021 оны 09 дүгээр сараас хойш долоо хоногийн Пүрэв гараг бүрт нийт 14 удаа тайлан хүргүүлсэн.<br>**Үнэлгээ 70 хувь** |
| 33 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, эрсдэлд суурилсан дотоод аудит хийх, холбогдох зөвлөмжийг хүргүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>-Гаалийн байгууллагад хэрэгжиж байгаа эрсдэлийн удирдлага нь зөвхөн гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжиж байна. Гаалийн байгууллагын бүх шатанд эрсдэл тооцох тогтолцоо бүрдээгүй.<br>Байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын | 2021 он<br>-“Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх дүрэм” боловсруулсан байна.<br>-Гаалийн ерөнхий газрын 2-3 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон 18 харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон | 1. Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар батлагдсан “Гааль, татварын албаны үйл ажиллагаанд дотоод аудит хийх заавар”-ыг Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/173 дугаар тушаалаар хүчингүй болгосон. Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-д дотоод аудит хариуцсан нэгж нь холбогдох хууль тогтоомжид үндэслэн “Дотоод аудитын дүрэм”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба өөрийн онцлогт тохирсон нэгжийн дүрэмтэй байж болно” гэж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | баримт бичгийг боловсруулж, батлуулах шаардлагатай.<br>-Гаалийн ерөнхий газрын 2-3 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын болон 18 харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, тайлан, зөвлөмжийг хүргүүлэн, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулсан.<br>Гаалийн байгууллагын эрсдэлийн тогтолцоог нэвтрүүлээгүй байна. | төлөвлөгөөт бус дотоод аудит хийнэ.<br>-Дотоод аудит хийсэн нэгжүүдэд тайлан, зөвлөмжийг хүргүүлэн, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулж, хэрэгжилтийг хангуулна.<br>2022 он<br>-Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулна.<br>-Байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч эхэлсэн, байгууллагын түвшний эрсдэлийн удирдлагын чиглэлээр явуулах сургалтын хөтөлбөр, агуулга, гарын авлага, заавар, аргачлалыг батлуулсан, эрсдэлийг удирдах туршлага, чадвар дээшилсэн байна.<br>-Гаалийн ерөнхий газрын 2-3 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон 18 харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийнэ.<br>-Дотоод аудит хийсэн нэгжүүдэд тайлан, зөвлөмжийг хүргүүлэн, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулж, хэрэгжилтийг хангуулна. | заасны дагуу байгууллагын эрсдэлд суурилсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/256 дугаар тушаалаар батлуулсан.<br>2. 2021 онд төлөвлөгөөт 4 дотоод аудит, төлөвлөгөөт бус 2 дотоод аудитыг, 2022 онд 11 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>-2020 оны Гаалийн хяналтын зорилгоор ашиглах ломбоны бүртгэл, зарцуулалтад өндөр дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитад нийт 9 гаалийн газар, хороог хамруулсан бөгөөд “Хангалттай” гэсэн дүгнэлт гарсан.<br>-Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хороо, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хорооны 2019, 2020 онд нөхөн бичсэн “Гаалийн бүрдүүлэлтийн хуудас /Маягт №2/”-ын бичилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр 7 асуудал илэрсэн бөгөөд “Сайжруулалт хэрэгтэй” – гэсэн дүгнэлт гарсан.<br>-Гаалийн байгууллагын 2020 оны жилийн эцсийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийхэд хэрэгжилт 98.59 хувьтай байсан. 8 зөвлөмжийг нийт 14 харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн. Тайланг 2021 оны 01-7/1097 тоот албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэв.<br>2020 оны эхний хагас жилд 98.72 хувьтай байсан бол 2021 оны эхний хагас жилд хийгдсэн дотоод аудитаар 99,83 хувь буюу 1.11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Шилэн дансны 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг 2021 оны 01-1/1659 албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэв.<br>-Гаалийн төв лабораторийн 2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна.<br>-Инженер техникийн албаны 2019, 2020, 2021 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна.<br>-Гаалийн шинэчлэл төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн явцад дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Нууцын зэрэглэлтэй материалд хийгдсэн аудит учраас Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулагдаагүй.<br>-БНХАУ-тай хиллэдэг 8 хилийн боомтуудын ижилтгэсэн манифестын 2021 оны хэрэгжилтэд хийсэн дотоод аудит,<br>-Импортын шуудангийн 2021 оны “Бусад” төлөвөөр хаасан манифестад хийсэн дотоод аудит,<br>-Гаалийн ерөнхий газрын даргын батлагдсан удирдамжийн дагуу Дорнод аймаг дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газрын 2021, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит,<br>-Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төвийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит,<br>-Шилэн дансны 2022 оны хэрэгжилтийн дотоод аудит.<br>3. Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхээр "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ыг Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/342 дугаар тушаалаар батлуулсан.<br>4. Байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч эхэлсэн, байгууллагын түвшний эрсдэлийн удирдлагын чиглэлээр эрсдэлийг удирдах үнэлэх, тогтоох зааварчилгаа болох техникийн баримт бичгийг боловсруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>5. Аудитын мөрөөр 416 зөвлөмжийг хүргүүлэн илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Үнэлгээ 90 хувь** |
| 34 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Байгууллагын төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн сахилга батыг хангах, төлбөр тооцооны цахим системд шилжих | Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр, Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2020 он<br>-Гаалийн байгууллагын 2020 оны урсгал зардлын батлагдсан төсөв 47’950.8 сая төгрөг, төсвийн гүйцэтгэл 2016-2019 онуудад жилд дунджаар 8 хувийн төсвийн хэмнэлттэй ажилласан байна.<br>-Худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаандаа зохион байгуулаагүй учраас он дамжсан өр, авлага үүсэх нөхцөл бүрддэг.<br>-Үндсэн хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр хяналт тавьсан байна.<br>-Төрийн сангийн гүйлгээг цаасаар биечлэн очиж хийдэг. | 2021 он<br>-Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсны үндсэн дээр үүссэн хэмнэлтийн хувь хэмжээ өмнөх оноос буураагүй байна.<br>-Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулан шинээр өглөг, авлага үүсгээгүй байна.<br>-Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт 96 хувиас дээш үнэлэгдсэн байна.<br>-Сангийн яамны Төрийн сангаас зохион байгуулах “Төлбөр тооцооны цахим систем”-д шилжихэд шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь хүргүүлсэн байна.<br>-Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрууд төлбөр тооцооны цахим системд шилжсэн байна<br>2022 он<br>-Байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн, батлуулж, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсны үндсэн дээр үүссэн хэмнэлтийн хувь | Гаалийн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр батлагдсан Гаалийн ерөнхий газрын даргын “Албан даалгавар” болон “Гаалийн байгууллагын урсгал зардлын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх зөвлөмж”-ийн хэрэгжилтийг ханган Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллын зааврыг мөрдөж, батлагдсан урсгал зардлын төсвийг 2020, 2021 онуудад 18-25 хүртэл хувиар хэмнэн ажилласан байна.<br>Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар хороод нэвтрэлтийн нэгдсэн системд шилжиж цалингийн болон хөрөнгө оруулалтын гүйлгээг цахимаар тоон гарын үсгээр баталгаажуулан гүйцэтгэж байна. Мөн төлбөрийн баримтыг e-invoice.ebarimt.mn-д үүсгэн ажиллаж байна.<br>**Үнэлгээ 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээ өмнөх оноос буураагүй байна.<br>-Тайлант оны худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулан шинээр өглөг, авлага үүсгээгүй байна.<br>-Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт 96 хувиас дээш үнэлэгдсэн байна.<br>-Орон нутаг дахь харьяа гаалийн газар, хороод төлбөр тооцооны цахим системд бүрэн шилжсэн байна | |
| Ерөнхий чиг үүргийн нэр: Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гаалийн хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. | | | | | | |
| Үндсэн чиг үүргийн нэр: Хилийн боомтын барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцан зохион байгуулах, хилийн хяналтын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах. | | | | | | |
| 35 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | Хэрэгжилт, хувиар | 2020 он<br>-Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Сүхбаатар боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын ажил 2019 онд эхэлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл дараах байдалтай байна:<br>-Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь,<br>-Гашуунсухайт боомтод бэлтгэл ажлууд хийгдэж байна.<br>-Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 15 хувь,<br>-Сүхбаатар боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын | 2021 он<br>-Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь,<br>-Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь,<br>-Алтанбулаг боомтын барилга, байгууламж, авто зам, зогсоолын барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь,<br>-Сүхбаатар боомтын Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь,<br>-Боршоо боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 80 хувь,<br>-Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэл 30 хувь | Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас барилгын ажлын гүйцэтгэгч компанийн хятад инженер, мэргэшсэн ажилтнууд Монгол улсад орж ирэх боломжгүй болсон, Замын-Үүд хилийн боомтод үүссэн дараалал болон хил хаасантай холбоотойгоор барилгын материалуудыг татан авах ажил удааширч, хатуу хөл хорио тогтоосон хугацаагаар ажил гүйцэтгэх хугацаа хойшилсон, барилгын материалын үнийн өсөлт зэрэг хүндрэл бэрхшээлийн улмаас боомтуудын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 2021 онд зорилтот хувьд хүрээгүй. Боомтуудын бүтээн байгуулалтын барилгын ажил удаааширсантай холбоотойгоор 2022 онд дараах арга хэмжээг авч ажилласан.<br>-Замын-Үүд, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалтын барилгын ажилд шаардлагатай цементийг хилээр нэвтрүүлэх асуудлыг БНХАУ-ын Эрээн, Ганцмод боомтын албатай онлайн хурал хийж шийдвэрлэх тухай чиглэлийг Замын-Үүд дэх гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газарт тус тус өгсөн.<br>- Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын барилгын бараа материал, техник хэрэгслийг очер |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гүйцэтгэл 44 хувь,<br>-Боршоо боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 48 хувь,<br>-Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.<br>-Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь,<br>-Шивээхүрэн хилийн боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх концепци батлагдсан.<br>-Булган болон Ханги боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн.<br>-Баянхошуу боомтод хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил хийгдээгүй. -“Цагаандэл-Уул” боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.<br>-Автозамын хилийн зарим боомтод суурилуулах ухаалаг гарцын системийн байршлыг урьдчилсан байдлаар төлөвлөсөн. | Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь,<br>-Шивээхүрэн боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл 100 хувь,<br>-Булган боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэл 20 хувь,<br>-Цагаандэл-Уул боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл 100 хувь, бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.<br>-Автозамын хилийн Алтанбулаг, Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт, Бичигт, Боршоо, Цагаандэл-Уул боомтод суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн байршлыг тогтооно.<br>2022 он<br>-Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссан байна. Хэрэгжилт 100 хувь,<br>-Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь<br>-Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын | дараалалгүй хилээр нэвтрүүлж, цогцолборын барилга дээр тээврийн хэрэгслийг оруулах тухай чиглэлийг Замын-Үүд дэх гаалийн газарт өгсөн.<br>- Замын-Үүд, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалтын ажиллах хүчийг хилийн зурвас газарт нэвтрүүлэхэд Хил хамгаалах ерөнхий газартай хамтран холбогдох арга хэмжээг авч, барилгын ажлыг хэвийн явуулах нөхцөлийг хангасан.<br>1.Замын-Үүд, Гашуунсухайт, Алтанбулаг, Боршоо боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн бүтээн байгуулалт:<br>-Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын нийт гүйцэтгэл 90%.<br>Замын-Үүд хилийн боомтын Зорчигч, тээврийн цогцолбор ашиглалтад орохтой холбогдуулан барилга, байгууламжийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд барилгын тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, суурилуулах, гаалийн хяналт, шалгалтын зарим тоног төхөөрөмжийн судалгаа, тооцооллыг гаргаж, Сангийн яаманд танилцуулж, 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сангийн сайдын багцаас буюу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлсэн.Зорчигч тээврийн хэсгийн бүтээн байгуулалтын барилгын ажил 97%-д хүрч, барилга байгууламж, зам талбайн барилгын ажлыг 2023 оны 1 дүгээр сард Улсын комисс хүлээн авна. Замын-Үүд-Эрээн боомтын зорчигч тээврийн хөдөлгөөнийг эхлүүлэхтэй холбогдуулан 2023 оны 1 дүгээр сард нээлтийг хийхээр бэлтгэл ажил хийгдэж байна. Замын-Үүд боомтын ачаа тээврийн хэсгийн барилгын ажлын гүйцэтгэл 80%-тай байна.<br>-Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажилд цар тахлын нөхцөл байдлын улмаас төслийн гадаад ажилчид хилээр орж ирэхэд хүндрэл үүссэн учир ерөнхий гүйцэтгэгч Жунмей интернэшнл ХХК нь туслан гүйцэтгэгчээр Монгол улсын 5 компанитай гэрээ байгуулан бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд эхлүүлсэн. Гашуунсухайт боомтын барилгын ажлын нийт гүйцэтгэл 15.4%.<br>-Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын нийт гүйцэтгэл 64.5%. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь,<br>-Булган боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэл 100 хувь, шинэчилсэн бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь.<br>-Баянхошуу боомтын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэл 30 хувь,<br>-Ханги боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэл 30 хувь,<br>-Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.<br>- Автозамын хилийн Алтанбулаг, Боршоо боомтод ухаалаг гарцын системийг нэвтрүүлсэн байна. | -Боршоо боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын нийт гүйцэтгэл 97%-д хүрсэн. Боршоо боомтын зарим барилга байгууламж, зам талбайг ашиглалтад оруулахаар Улсын комисс 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ажиллаж, барилга байгууламжуудыг хэсэгчлэн хүлээж авсан.<br>2.Сүхбаатар боомтын Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгын ажлын гүйцэтгэл 99%-д хүрсэн. Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгыг ашиглалтад оруулахаар Улсын комисс 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан.<br>3.Хөшигийн хөндийн Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга байгууламжуудын барилгын ажлын нийт гүйцэтгэл 93%-д хүрсэн. Тус нэг нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулахаар Улсын комисс 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан.<br>4.Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эхний тендер шалгаруулалтыг 2021 онд Сангийн яамнаас хүчингүй болгож, дахин үнэлгээний хороог Гаалийн ерөнхий газрын дэд дарга Ц.Гэндэнцэвээнээр ахлуулан байгуулсан. Үнэлгээний хорооны гишүүн Сангийн яамны төлөөлөл, ХБҮЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга солигдсон тул дахин үнэлгээний хороог байгуулах шаардлагатай болсон бөгөөд үнэлгээний хороо 2022 онд дахин байгуулагдсан. Тус боомтын барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зарласан.Үнэлгээний хорооноос Бичигт хилийн боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд Сангийн яам гүйцэтгэгчтэй 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулсан.<br>Бичигт хилийн боомтын барилга угсралтын ажлын тендерийг дахин зарлахын тулд гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний төрлийг нэгж үнийн гэрээ болгон өөрчилж, гэрээний хэрэгжилтийн хугацаанд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнийн тохируулга хийх заалт тусгах саналыг Үнэлгээний хороо гаргасныг захиалагч хүлээн зөвшөөрсөн, тендерийг 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр дахин зарлана.<br>5.ХБҮЗ-ийн 2021 оны 02 дугаар тогтоолоор Шивээхүрэн, Ханги, Булган, Бургастай, Цагааннуур, Ханх, Ульхан, Баянхошуу, Хавирга, Сүмбэр боомтуудыг хөгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. Үүний дагуу Сангийн яамны дэргэдэх “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгжээс зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2021 онд гэрээ байгуулсан. Боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгж болон гүйцэтгэгч компаниудад өгч, судалгааны ажлыг 2021 онд эхлүүлсэн. Боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд барилга байгууламж, гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжүүдийн байршлын талаарх ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулж, гүйцэтгэгч байгууллагад өгч, эскиз зураг төслийг 2022 оны 2-3 дугаар улиралд батлуулсан. Батлагдсан эскиз зураг төсөлд тусгагдсан барилга байгууламжууд, гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжүүдийн нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаварт тусгах техникийн үзүүлэлт, тодорхойлолт, холбогдох санал, зөвлөмжийг гүйцэтгэгч байгууллагад өгч, хамтран ажиллаж байна. Боомтуудын зураг төсөл боловсруулах ажил 87,8%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Шивээхүрэн боомт 93%, Булган боомт 75%, Баянхошуу боомт 85%, Ханги боомт 80%, Цагааннуур боомт 90%, Ханх боомт 86%, Ульхан боомт 95%, Хавирга боомт 97%, Сүмбэр боомт 85%, Бургастай боомт 92%<br>6. Цагаандэл уул-Өлзий боомтын зураг төслийн ажил 100% хийгдэж, гаалийн байгууллагаас зураг төслийг хянасан. Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 55 тоот тэмдэглэлийн дагуу Цагаандэл уул боомтыг 2021 оны 10 дугаар сарын 20-25-ны өдрийг дуусталх хугацаанд түр горимоор нээж, тоног төхөөрөмж, зөөврийн орон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сууц, бараа материалыг татан авсан. Цагаандэл уул боомтыг 2022 оны 07 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд түр горимоор нээж, Хятадын талаас барилгын ажлын 2-р ээлжийн тоног төхөөрөмж, бараа, материалыг хилээр нэвтрүүлсэн. Цагаандэл уул боомтын түр гарцын барилгын ажлын явц 70%-тай байна.Тус боомтод төлөвлөсөн лаборатори болон халдваргүйтгэлийн барилгын инженерийн нарийвчилсан зураг төслийн технологийн даалгаврыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 03-3/1264 албан бичгээр хүргүүлсэн.<br>Тайлбар: БНХАУ-ын ӨМӨЗО-ын Альшаа аймгийн захиргаанаас Цагаандэл уул-Өлзий боомтын бүтээн байгуулалтын буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлэх, хяналт тавих, зохион байгуулах тухай 4 талт гэрээг цуцлахыг зөвшөөрсөн албан бичгийг 2022 оны 11дүгээр сарын 03-ны өдөр ирүүлсэн. “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгжээс Бүтээн байгуулалтын тусламжийн төсөл хэрэгжүүлэх 4 талт гэрээг цуцлах мэдэгдлийг “Үлэмж” ХХК-д хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэлийг шалгах ажил хийгдэж байна.<br>7.Автозамын боомтуудад гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж суурилуулах ажил:<br>7.1 Шивээхүрэн боомтод ачааны авто машин шалгах рентген төхөөрөмж суурилуулах талбайн координат, байршлын цэгийг Гаалийн ерөнхий газрын ажлын хэсэг геодези зураг зүйн “Трайминерал марк” ХХК-тай хамтран газар дээр нь очиж тогтоосон бөгөөд суурилуулалтын ажлыг 2021 онд дуусгасан. Рентген төхөөрөмжийг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч, гаалийн хяналт, шалгалтад ашиглаж байна. Шивээхүрэн боомтод дээж авагч төхөөрөмжийн суурийн ажлыг 2021 онд эхлүүлсэн бөгөөд 90%-ийн гүйцэтгэлтэй. Шивээхүрэн боомтын нүүрс тээврийн хэсэгт суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн байршил, тоо хэмжээг гарган Мейжүрмэнт ХХК-д 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 03-3/1880 албан бичгээр хүргүүлсэн. Шивээхүрэн боомтод суурилуулахаар төлөвлөсөн рентген, дээж авагч төхөөрөмж, авто пүү, болон гаалийн хяналтын бүсэд суурилуулах ухаалаг гарцын иж бүрдэлд шаардлагатай тоног |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжүүдийн жагсаалт, тоо хэмжээг эцэслэн гаргаж, ухаалаг гарцын шинэчилсэн төсөв гаргаж ирүүлэх тухай албан бичгийг Мэйжүрмент ХХК-нд 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 03-3/2179 албан бичгээр хүргүүлсэн. Шивээхүрэн боомтын нүүрс тээврийн хэсэгт ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдийг орох, гарах 16 гарцуудад суурилуулсан. Ухаалаг гарцын суурилуулалтын ажлын явц 87%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>7.2 Гашуунсухайт боомтод байгуулагдсан Чингэлэгт тээврийн терминалд гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, туршилтыг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хийсэн бөгөөд тус боомтоор 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар өдөрт 144 тээврийн хэрэгслээр 288 чингэлэг нүүрс экспортолсон. Гашуунсухайт боомтын 16 түр гарц дээр ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдийг суурилуулахаар байршлыг тодорхойлсон.<br>7.3 Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн хэсэгт ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахаар дэд бүтцийн шугам сүлжээ, сувагчлал, суурийн ажлууд хийгдсэн.<br>7.4 Алтанбулаг боомтод шинээр суурилуулах ухаалаг гарцын систем, автопүү болон рентген төхөөрөмжүүдийн байршлыг батлагдсан зураг төсөлд тусгаж, барилга угсралтын зардлыг төслийн хүрээнд шийдвэрлүүлэх асуудлаар Сангийн яам болон АХБ-ны RIBS төслийн нэгжтэй 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр уулзалт хийж, гүйцэтгэгч компанийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Гаалийн ерөнхий газраас Алтанбулаг, Боршоо боомтуудад суурилуулах авторентген, автопүү, ухаалаг гарцын байршлын санал болон тоног төхөөрөмжүүдийн тоо хэмжээ, техникийн үзүүлэлтийг нэгтгэн гаргаж, RIBS төслийн нэгжид 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/1428 албан бичгээр хүргүүлсэн.<br>Алтанбулаг, Замын-Үүд, Сүхбаатар, Боршоо боомтуудад суурилуулах телехяналтын камер, ухаалаг гарцын тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын төсвийг АХБ-ны нэмэлт санхүүжилтээр шийдвэрлэхээр "RIBS" төслийн нэгжтэй 2022 оны 08дугаар сарын 19-ний өдөр уулзалт зохион |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан. Тус уулзалтын хурлын шийдвэрийн дагуу Алтанбулаг, Боршоо боомтод суурилуулах ухаалаг гарц, телехяналтын системийн камерыг тоо хэмжээ, тооцоо судалгааг нэгтгэн гаргаж, техникийн үзүүлэлт, тавигдах шаардлагыг АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 02/2596 албан бичгээр хүргүүлсэн.<br>Алтанбулаг, Замын-Үүд боомтуудын зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт суурилуулах гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжүүдийн тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, тавигдах шаардлагыг АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 02/3471 албан бичгээр хүргүүлсэн. Алтанбулаг боомтод суурилуулах гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, ухаалаг гарц, телехяналтын камерын байршлыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний батлагдсан зураг төсөлд тусгуулахаар өөрчлөлтийн зургийг “Монкон” ХХК гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар оруулж батлуулсан.<br>-Боршоо боомтод рентген төхөөрөмж суурилуулах бэлтгэл ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газраас ажлын хэсэг 2022 оны 09 дүгээр сарын 02-05-ны өдрүүдэд газар дээр нь ажиллаж, байршлыг тогтоон солбилцлын цэгийг “Аврора консалтинг” ХХК-д хүлээлгэн өгсөн. Увс аймаг дахь гаалийн газар рентген төхөөрөмжийг ОХУ-аас хүлээн авсан бөгөөд удирдлагын байрны суурийн ажил хийгдэж дууссан.<br>**Үнэлгээ 70 хувь** |
| 36 | ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | Гаалийн төв болон салбар лабораторийн чадавхыг бэхжүүлэх | Дээжийн тоо, хувиар, Магадлан шинжилгээнд зарцуулах хугацаа, хоногоор | 2020 он<br>-Гаалийн төв болон салбар лабораториуд нь эрдэс түүхий эд, нүүрс, нефтийн зарим бүтээгдэхүүнд шинжилгээний тоног төхөөрөмжгүйгээс магадлан шинжилгээг хийх боломжгүй байсан тул бусад итгэмжлэгдсэн лабораториудаар нийт | 2021 он<br>-Гаалийн төв лабораторийн болон Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газарт эрдэс түүхий эд, нүүрсний, нефтийн чиглэлээр, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагааннуур, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу дахь салбар лабораторийг нефтийн | Гаалийн шинэчлэлийн хүрээнд байгуулсан Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагаан нуур, Сайншанд дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомтуудын салбар лабораториудад нийт 90 шинжилгээний тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, бүрэн ашиглалтад оруулсан.<br>2021 оны байдлаар хилийн боомтууд дээр ажиллаж байгаа гаалийн 4 салбар лабораториуд нь 631 төрлийн 2677 дээжид магадлан шинжилгээг холбогдох стандартын дагуу хийж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2300 дээжид шинжилгээ хийлгэж, үр дүнг үндэслэн барааны ангиллын кодыг тодорхойлон дүгнэлт гаргасан.<br>-Гаалийн газар, хороодоос Гаалийн төв лабораторийн магадлан шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах хүртэл дунджаар 5-7 хоногийг зарцуулж байна. Иймээс 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр /19,953 тэр бум төгрөг/ Гаалийн төв лаборатори болон ОрГГ, СШГГ-т эрдэс түүхий эд, нүүрсний, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр, Цагааннуур, Баянхошуу боомт дахь салбар лабораторийг нефтийн шинжилгээний чиглэлээр, ГСГГ-ын Оюутолгой дахь салбар лабораторийг эрдсийн шинжилгээний чиглэлээр байгуулж, шинжилгээний тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, суурилуулахаар ажиллаж байна.<br>Алтанбулаг, Замын- Үүд дэх Хилийн мэргэжлийн хяналтын албаны лабораторийг Гаалийн лабораторитой нэгтгэж, хорио цээрийн шинжилгээг хийж байна. | чиглэлээр, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой дахь салбар лабораторийг эрдсийн чиглэлээр шинжилгээний тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, суурилуулж, үйл ажиллагаанд оруулснаар магадлан шинжилгээнд хамрагдах нийт дээжийн тоог 15-20 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Орхон аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Цагааннуур, Баянхошуу боомт, Гашуунсухайт гаалийн газрын Оюутолгой гаалийн хяналтын бүсэд салбар лабораториудыг шинээр байгуулснаар тус гаалийн газруудын хяналтад байгаа барааны магадлан шинжилгээнд зарцуулах хугацааг 2-3 хоногоор бууруулна.<br>2022 он<br>-Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораторийг нефтийн бүтээгдэхүүн, ноос ноолуурын шинжилгээний чиглэлээр, Алтанбулагийн боомтын салбарыг согтууруулах ундаа, хими, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр, Дорнод аймаг дахь гаалийн газрын салбар лабораторийг хими, нефтийн шинжилгээний чиглэлээр өргөтгөж, Хөшигийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын | хийж, 2084 дүгнэлт гаргасан. Үүнд:<br>• Замын-Үүд дэх гаалийн салбар лаборатори: 375 төрлийн 1170 дээж, 823 дүгнэлт,<br>• Алтанбулаг дахь гаалийн салбар лаборатори: 181 төрлийн 336 дээж, 173 дүгнэлт,<br>• Дорнод аймгийн гаалийн салбар лаборатори: 46 төрлийн 280 дээж, 280 дүгнэлт,<br>• Чойр дахь гаалийн салбар лаборатори: 3 төрлийн 891 дээж, 808 дүгнэлтийг тус бүр гаргасан байна.<br>Нийт гаргасан дүгнэлтийн 858 буюу 41.2% нь экспорт, 1226 буюу 58.8% нь импортын бараанд хамаарч байна.Тухайн гаалийн газраас магадлан шинжилгээнд хамруулах хугацааг 2-3 хоногоор бууруулж ажилласан. Үүний үр дүнд татварыг бүрэн авах боломжийг бүрдүүлсэн.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар гаалийн 6 салбар лабораториуд нийт 15526 дээжид шинжилгээ хийж, 7501 дүгнэлт гаргажээ. Үүнээс: Гаалийн зорилгоор 4719 дээжид 3887 дүгнэлт, хорио цээрийн чиглэлээр 10807 дээжид 3614 дүгнэлтийг тус тус гаргасан байна. .<br>2.“Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан. 2022 оны хөрөнгө оруулалтаар 6.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 182 тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэн, гэрээ байгуулан захиалснаас эхний 155 тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br>-Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораторийн шинжилгээний хүрээг өргөжүүлэх зорилгоор ноос, ноолуурын шинжилгээний чиглэлээр 5 тоног төхөөрөмж нийлүүлэхээс 5 тоног төхөөрөмжийг суурилуулан, тохиргоо хийж, сургалт явуулан, хүлээлгэн өгснөөр хэвийн ашиглаж байна. Харин тус салбар лабораторийн барилга бүрэн дуусаагүй байгаатай холбогдуулан нефтийн бүтээгдэхүүний тоног төхөөрөмжүүдийн санхүүжилтийг 2023 онд тусгахаар шийдвэрлэсэн.<br>- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Алтанбулаг боомтын салбар лабораторийн барилга бүрэн дуусаагүй байгаатай холбогдуулан согтууруулах ундаа, химийн бодис, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нисэх буудалд хими, мансууруулах бодисын шинжилгээ Боршоо боомтод нефтийн бүтээгдэхүүний шинжилгээ, Бичигт боомтод эрдэс, нүүрс, нефтийн бүтэгдэхүүний чиглэлээр тус тус салбар лабораторийг байгуулан, шинжилгээний тоног төхөөрөмжийг, суурилуулан, үйл ажиллагаанд оруулснаар магадлан шинжилгээнд хамрагдах нийт дээжийн тоог 15-20 хувиар нэмэгдүүлнэ.<br>-Хөшигийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх буудал, Боршоо, Бичигт боомтод салбар лабораторийг шинээр байгуулснаар тус гаалийн газрын хяналтад байгаа барааны магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 1-4 хоногоор бууруулна. | гаргасан боловч санхүүжилтийг 2023 онд тусгахаар шийдвэрлэсэн.<br>- Дорнод аймаг дахь гаалийн газар болон шинээр байгуулагдаж байгаа Хөшгийн хөндий, Боршоо боомтын салбар лабораторид шаардлагатай химийн бодис, нүүрс, нефть, хүнсний эрүүл ахуйн шинжилгээний тоног төхөөрөмжийн санхүүжилтийг гаалийн байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалтад тусган шийдвэрлүүлснээс одоогийн байдлаар нефтийн бүтээгдэхүүн шинжлэх зориулалттай 22, , эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр 59 тоног төхөөрөмж нийлүүлэгдээд байна.<br>- Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лабораторийг шинээр байгуулан, хими, мансууруулах бодисын шинжилгээний чиглэлээр 4, эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр 22 тоног төхөөрөмж захиалсан бөгөөд одоогийн байдлаар химийн бодис шинжлэх зориулалттай 3, хорио цээрийн 22 тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Тус салбар лабораторийн барилга бэлэн болоогүй тул Гаалийн төв лабораторид хүлээн авсан.<br>Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтод салбар лабораторийг шинээр байгуулж, нефтийн бүтээгдэхүүний чиглэлээр 12, эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр 22 тоног төхөөрөмж захиалсан бөгөөд одоогийн байдлаар нефтийн бүтээгдэхүүний 11, хорио цээрийн 22 төхөөрөмжийг нийлүүлээд байна. Тус салбар лабораторийн барилга бэлэн болоогүй тул Гаалийн төв лабораторид хүлээн авсан.<br>Сүхбаатар аймгийн Бичигт боомтын шинэчлэл хийхээр төлөвлөгдөж байгаа тул эрдэс, түүхий эд, нүүрс, нефтийн шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн судалгааг гаргасан бөгөөд 2023-2024 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.<br>Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газрын Оюутолгой, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомтын салбар лабораториудын шинжилгээний тоног төхөөрөмжүүдийг ашиглалтад бүрэн оруулснаар нийт 1736 дээжид магадлан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээг хийж, 1661 дүгнэлт гаргасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дээрх салбар лабораториудын шинжилгээнд хамрагдсан дээжний тоог 69,6%-иар нэмэгдүүлж, тухайн гаалийн газрын хяналтад байсан барааны магадлан шинжилгээнд хамруулах хугацааг 2-3 хоногоор бууруулж ажилласан. **Үнэлгээ 100 хувь** |
| **Нийт дундаж 88.3 хувь** | | | | | | |